

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙН ТУХАЙ ТУНХАГЛАЛ+25

НҮБ-ын Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний
эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн
дэмжих, хувь хүн, нийгмийн нэгж,
байгууллагын эрх, үүргийн тунхаглал
(Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал)
Тунхаглалыг дэмжих нь: 25 жил

2025 он

НАА 67
ДАА 340
Х- 828

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧИЙН ТУХАЙ ТУНХАГЛАЛ + 25

НҮБ-ын Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих хувь хүн, бүлэг, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тухай (Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал) Тунхаглалыг дэмжих нь: 25 жил

2025 он

Орчуулгын тухай

Энэхүү баримт бичиг нь одоогоор англи, араб, франц, испани хэл дээр гарсан. Баримт бичгийг бусад хэл рүү орчуулахыг сайшаана. Хэрэв та энэхүү баримт бичгийг орчуулах, эсхүл орчуулгад хувь нэмрээ оруулахаар төлөвлөж байгаа бол баримт бичигт тусгагдсан мэдээллийн бүрэн бүтэн, хамааралтай байдлыг хангахын тулд бидэнтэй урьдчилан холбогдоно уу.

Энэхүү хувилбарыг 2024 оны 06 дугаар сард нийтэлж, 2024 оны 10 дугаар сард шинэчилсэн.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Хүний эрхийн Олон Улсын Үйлчилгээ (International Service for Human Rights (ISHR)) байгууллагын зөвшөөрлөөр орчуулж, хэвлүүлэн олон нийтийн хүртээл болгож байна.

Хянасан: С.Дондов
ХЭҮК-ын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн
З.Өнөржаргал
ХЭҮК-ын Хүний эрх хамгаалагчийн хэлтсийн дарга

Орчуулсан: Р.Очирбал
Хуульч, судлаач

Хянан тохиолдуулсан: Д.Ханд, орчуулагч

Эмхэтгэсэн: А.Балдангомбо
ХЭҮК-ын Хүний эрх хамгаалагчийн хороо хариуцсан ажилтан

ISBN: 978-9919-9224-1-2

Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал + 25

НҮБ-ын Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг
хамгаалах, хөхиүлэн дэмжих, хувь хүн, нийгмийн нэгж,
байгууллагын эрх, үүргийн тунхаглал (Хүний эрх хамгаалагчийн тухай
тунхаглал) Тунхаглалыг дэмжих нь: 25 жил

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА	3
-------------------	---

ТУНХАГЛАЛ+25-Д ГАРЫН ҮСЭГ ЗУРАГЧИД	6
--	---

УДИРТГАЛ	9
----------------	---

I БҮЛЭГ – ХҮНИЙ ЭРХИЙГ ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ, ХАМГААЛАХ

ЭРХИЙГ ТОДОРХОЙЛОХ, ДАХИН БАТЛАХ НЬ	11
---	----

1 дүгээр зүйл: Хүний эрх хамгаалагчийн тодорхойлолт	11	2 дугаар зүйл: Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах эрхийг дахин батлах нь	12
---	----	---	----

II БҮЛЭГ – ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫН ЭРХ, ТҮҮНИЙГ ХАМГААЛАХ НЬ ... 13

3 дугаар зүйл: Хүний эрх хамгаалах эрхийг хүлээн зөвшөөрөх	13	8 дугаар зүйл: Хүний эрх хамгаалагчдын гэр бүл, төрөл садан, хамтран зүтгэгч, төлөөлөгч болон бүлгийг хамгаалах	21
--	----	--	----

4 дүгээр зүйл: Хүний эрх хамгаалах эрхийг хэрэгжүүлэх аюулгүй, таатай орчны эрх	14	9 дүгээр зүйл: Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хүртээмж болон технологиор дөхөм болсон хүний эрхийн зөрчлийн шинэ болон шинээр үүсэж буй хэлбэрээс хамгаалах	21
--	----	---	----

5 дугаар зүйл: Гутаан доромжлолт, гэмт хэрэгт тооцохоос хамгаалах	16	10 дугаар зүйл: Нөөцийн хүртээмж	24
---	----	-------------------------------------	----

6 дугаар зүйл: Эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдал, хамгаалалт	17	11 дүгээр зүйл: Мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын үеийн эрх ба хамгаалалт	25
---	----	--	----

7 дугаар зүйл: Эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдын иж бүрэн хамгаалалт	19
--	----

III БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДАД ЧИГЛЭСЭН ЭРХ,

ХАМГААЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ	11
-----------------------------	----

12 дугаар зүйл: Тунхаглал болон Тунхаглал+25-ын хэрэгжилт	28	16 дугаар зүйл: Улсын нутаг дэвсгэрийн гадна болон гадагш чиглэсэн зөрчилд хариу арга хэмжээ авах нь	32
---	----	---	----

13 дугаар зүйл: Мониторинг ба тайлагналт	29	17 дугаар зүйл: Төрийн бус оролцогчдын талаар төрийн хүлээх үүрэг хариуцлага	33
---	----	--	----

14 дүгээр зүйл: Хүний эрх хамгаалагчдад дипломат дэмжлэг үзүүлэх	29	18 дугаар зүйл: Бизнесийн байгууллагуудын үүрэг, хариуцлага	32
--	----	---	----

15 дугаар зүйл: Нүүн шилжсэн, дүрвэсэн, эх орноосоо хөөгдсөн хүний эрх хамгаалагчдыг дэмжих	30	19 дүгээр зүйл: Олон улсын болон бүс нутгийн байгууллага, механизмын үүрэг, хариуцлага	32
---	----	--	----

ТАНИЛЦУУЛГА

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблей (цаашид “НҮБЕА” гэх) 1998 онд Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн (Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал) тунхаглал (цаашид “Тунхаглал” гэх)-ыг баталсны 25 жилийн ой 2023 онд болж өнгөрсөн.

Тунхаглалыг баталсан нь хүний эрхийн түүхэн дэх чухал өөрчлөлтийн эхлэл болсон юм. Тунхаглалаар хүний эрхийн үйл ажиллагааны ач холбогдол, хууль ёсны байдал болон хүний эрх хамгаалах эрхийг хамгаалах шаардлагатай болохыг хүлээн зөвшөөрсөн. Тунхаглалд хүний эрх хамгаалах үндсэн эрхийг баталгаажуулсны зэрэгцээ үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хуран цуглах зэрэг гол баримт бичгүүдэд тусгагдсан хүний эрхүүд хүний эрх хамгаалагчдын эрхэд хэрхэн хамаарахыг тодорхойлсон. Сүүлийн хорин таван жилийн хугацаанд эдгээр үндсэн дүрэм, зарчмууд нь хүний эрхийн төлөө тэмцэгчдийг дэмжих, хамгаалахад үндэсний, бүс нутаг, олон улсын хүчин чармайлтын удирдамж болж ирсэн юм.

Тунхаглалыг баталснаас хойш хорин жилийн дараа хүний эрх хамгаалагчид дэлхийн өнцөг булан бүрээс 2018 онд Парис хотноо болсон Хүний эрх хамгаалагчдын дэлхийн дээд хэмжээний уулзалтад хуран чуулав. Энэхүү дээд хэмжээний уулзалтаар Тунхаглалыг дахин баталгаажуулж, хүний эрх хамгаалагчдын үндсэн чиг үүргийг онцолсон. Дээд хэмжээний уулзалтын үр дүнд гарсан баримт бичигт “1998 оноос хойш хүний эрх хамгаалагчдыг хамгаалахтай холбоотой хэм хэмжээний тогтолцооны хөгжлийг дүгнэж, хамгаалалтыг сайжруулах үүднээс Тунхаглалд тусгагдсан хэм хэмжээг улам боловсронгуй болгож, гүнзгийрүүлэх арга хэмжээ авах”-ыг уриалав. Энэхүү “Тунхаглал+25”-ыг боловсруулахдаа иргэний нийгмийг түүний үйл ажиллагааны суурь асуудал болох хүний эрх хамгаалах эрхийг яриа хэлэлцээрийн төвд авч үзэхийг зорьсон.

Тунхаглалын үр нөлөөнөөс хамааралгүйгээр улс орнууд Тунхаглалыг хангалттай хэрэгжүүлж, мөрдөхгүй байгаагийн учраас тунхаглалын хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй хэвээр байна. Энэхүү Тунхаглалыг улс орнууд хэлэлцэн тохиролцож баталсан хэдий ч бүхнийг хамарсан болж чадаагүй. Үүнээс гадна Тунхаглал батлагдсанаас хойш хүний эрх хамгаалах эрхийг хүлээн зөвшөөрөх, хамгаалах талаарх олон улсын эрх зүй хөгжсөн. Хүний эрх хамгаалагчдад тулгарч буй аюул заналхийлэл, саад тотгорыг дахин зураглах шинэ сорилт, бэрхшээлүүд бий болов. Эдгээрт дижитал аюул заналхийлэл, гутаан доромжлол, гэмт хэрэгт тооцох, түүнчлэн хүний эрх хамгаалагчдын хувийн шинж байдал, үйл ажиллагаанаас нь бий болж байгаа өвөрмөц болон огтлолцсон эрсдэлүүд хамаарна.

Эдгээр сорилт, үйл явцыг хүлээн зөвшөөрч, олон улсын болон бүс нутгийн байгууллагуудын бүлэг Тунхаглалд тусгагдаагүй буюу хангалтгүй тусгагдсан хүний эрхийг хамгаалахад тулгарч буй гол асуудлуудыг тодорхойлох зөвлөлдөх санаачилгыг гаргав. Энэхүү санаачилгад хүний эрхийн хамгаалагчид, хууль, эрх зүйн болон хүний эрхийн мэргэжилтнүүд, иргэний нийгэм оролцсон тусгагдсан. Нэг жил гаруй хугацаанд дэлхийн янз бүрийн бүс нутгийн, янз бүрийн асуудал дээр ажилладаг 736 гаруй хүний эрхийн хамгаалагчид биечлэн зөвлөлдөх болон цахим

асуулга хэлбэрээр саналаа өгч хувь нэмрээ оруулав. Энэхүү баримт бичгийг боловсруулахад Фрешфилдс Брукхаус Дэринжер (Freshfields Bruckhaus Deringer) олон улсын хуулийн фирмийг про-боно хэлбэрээр ажиллуулж, Бангкок хотод болсон хоёр өдрийн уулзалтаар эцэслэж, янз бүрийн бүс нутаг, нэр хүнд бүхий хүний эрхийн хамгаалагчид, хуулийн мэргэжилтнүүд санал нэгтгэйгээр баталсан.

Дээрх санаачилгын үр дүн нь “Тунхаглал+25” юм. Энэхүү баримт бичиг нь Тунхаглалтай хамт уншигдахаар боловсруулагдсан болно. Эдгээр нь хамтдаа бүс нутгийн болон олон улсын эрх зүйд үндэслэсэн, бүс нутгийн болон олон улсын хууль зүйн сүүлийн 25 жилийн хөгжлийг харгалзан үзсэн цогц стандарт, зарчмууд болно. Эдгээр дүрэм, зарчмууд нь хүний эрх хамгаалагчдын байсаар байгаа болон өөрчлөгдөж буй хэрэгцээг хангахын зэрэгцээ тэднийг хамгаалах, хөхиүлэн дэмжих үндсэн суурь болно. “Тунхаглал+25” нь хүний эрх хамгаалагчдын эрх, хүний эрх хамгаалагчдад хамаарах олон улсын эрх зүйн дагуу улс орнуудын хүлээх үүргийг тодорхойлсон. Тунхаглал нь хүний эрх хамгаалах, хөхиүлэн дэмжих хүчирхэг, хамааралтай, үр дүнтэй хэрэгсэл хэвээр байх баталгааг хангахын тулд бүх оролцогч талууд болох Засгийн газар, олон улсын болон бүс нутгийн байгууллагууд, хувийн хэвшил, иргэний нийгэмд хандсан уриалга юм.

Нарийн бичгийн дарга нарын газрын гишүүд:

- Эмнести Интернэшнл (Amnesty International)
- Ази, Номхон Далайн Эмэгтэйчүүдийн эрх зүй, Хөгжлийн Форум (Asia Pacific Forum on Women Law and Development (APWLD))
- Хүний эрх, хөгжлийн төлөөх Азийн Форум (Asian Forum for Human Rights and Development (FORUM-ASIA))
- СИВИКУС (CIVICUS)
- Тэргүүн шугамын хамгаалагчид (Front Line Defenders)
- Хүний эрхийн Галф Төв (Gulf Centre for Human Rights)
- Олон улсын Лесбиан, Гей, Бисексуал, Транс, Интерсекс холбоо (The International Lesbian, Gay, Bisexual, Trans, and Intersex Association (ILGA World))
- Ашгийн бус эрх зүйн олон улсын төв (The International Center for Not-for-Profit Law (ICNL))
- Хүний эрхийн олон улсын холбоо (International Federation for Human Rights (FIDH))
- Хүний эрхийн Олон Улсын Үйлчилгээ (International Service for Human Rights (ISHR))
- Эмэгтэй хүний эрх хамгаалагчдын Месоамерикийн санаачилга (Meso-american Initiative of Women Human Rights Defenders (IM-Defensoras))
- Олон улсын Энхтайвны бригад (Peace Brigades International)
- ProtectDefenders.eu
- Олон улсын хамгаалалт (Protection International)
- Баруун Өмнөд Ази, Хойд Африк дахь эмэгтэй хүний эрхийн хамгаалагчдын бүс нутгийн эвсэл
- (The Regional Coalition for Women Human Rights Defenders in Southwest Asia and North Africa (WHRDMENA))
- Роберт Ф.Кеннеди Хүний эрх (Robert F.Kennedy Human Rights)
- Дэлхийн Эрүү Шүүлтийн Эсрэг байгууллага (World Organisation Against Torture (OMCT))

“ТУНХАГЛАЛ+25”-Д ГАРЫН ҮСЭГ ЗУРАГЧИД

2024 оны 04 дүгээр сарын 11-12-ны өдрүүдэд Шинжээчдийн уулзалтыг оролцуулан дор дурдсан хүний эрхийн шинжээч, хуульч, хамгаалагчид тус тусын хувиар “Тунхаглал+25”-ыг батлав.

- **Абделазиз Мухамат**
Хүний эрх хамгаалагч, Мартин Энналсийн шагналт, дүрвэгсэд, цагаачдын эрхийн төлөө тэмцэгч
- **Сесилия Хименез-Дамари**
Хуульч, Шилжилтийн шударга ёсны өмгөөлөгч
- **Экрачай Чайманикаракатэ**
Нөлөөллийн удирдагч, Хүний эрхийн Тай хуульч
- **Клемент Воул**
НҮБ-ын Хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөний асуудал хариуцсан Тусгай илтгэгч асан
- **Доктор Алис М.Нах**
Хүний эрх болон нийтийн эрх зүйн төвийн дэд захирал, Английн Дурхам их сургуулийн социологийн тэнхимийн дэд профессор
- **Кристина Палабей**
Карапатан Элайнс Филиппин ерөнхий нарийн бичгийн дарга
- **Ана Баррето**
Хар арьстан эмэгтэйчүүдийн Бодлогын Лаб, үүсгэн байгуулагч
- **Далила Аргуэта**
Эмэгтэй хүний эрх хамгаалагчдын Хондуран Үндэсний Сүлжээний гишүүн, Месоамерик Санаачилгын гишүүн
- **Анна Аннанон**
Хүүхдийн эрх болон иргэний эрхийн залуу хүний эрх хамгаалагч
- **Эд О'Донован**
НҮБ-ын Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан Тусгай илтгэгчийн ахлах зөвлөх
- **Анекса Альфред Каннингэм**
Хуульч, хүний эрх хамгаалагч, Уугуул хүмүүсийн эрхийн талаарх НҮБ-ын Шинжээчдийн механизмын гишүүн, Уугуул хүмүүс болон Афро хүмүүсийн үр хойчийн платформыг үүсгэн байгуулагч
- **Эрика Кастелланос**
Транс эрх, тэгш байдлын Глобал Үйл Ажиллагаа, гүйцэтгэх захирал

- **Бетти Барха**
Австралийн Их Сургууль, Манлайлал дахь эмэгтэйчүүдийн глобал хүрээлэнгийн судлаач
- **Бетти Йоланда**
Бизнес ба хүний эрхийн нөөцийн төв, Бүс нутгийн хөтөлбөрийн захирал
- **Бретт Соломон**
Аксесс Нов, гүйцэтгэх захирал
- **Хосе Луис Кабалеро Очоа**
Хүний эрх хамгаалагчийн Тусгай илтгэгч, Америк хоорондын Хүний эрхийн комиссын гишүүн
- **Луис Энрике Эгурен**
Хараат бус зөвлөх, Испанийн Дюсто их сургууль, зочин багш
- **Мар Сервантес**
Месоамерикийн Хүний эрх хамгаалагчийн санаачилга
- **Mary Lawlor**
НҮБ-ын Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч
- **Мээрим Ильяс**
Феминист идэвхтэн, Хууль зүйн Үйлчилгээний Корпораци, Олон талт, Тэгш болон Оролцоот хөтөлбөрийн менежер
- **Гама**
Хүний эрхийн хараат бус хамгаалагч
- **Хассан Шир**
Африкийн хүний эрх хамгаалагч төсөл (DefendDefenders), гүйцэтгэх захирал
- **Хориа Мосадик**
Аюулгүй байдал, Эрсдэлийг Бууруулах Байгууллага (SRMO), захирал
- **Филип Линч**
Хүний эрхийн Олон Улсын Үйлчилгээ, гүйцэтгэх захирал
- **Праном Сомвонг**
Тайланд Улсын төлөөлөл, олон улсын хамгаалалт
- **Реми Нгой Лумбу**
Хүний эрх болон Ард түмний эрхийн талаарх Африкийн Комиссын Ерөнхийлөгч, хүний эрх Хамгаалагчийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч
- **Мэри Лоулор**
Хуульчдын Олон улсын Комисс, Ерөнхий нарийн бичгийн дарга
- **Дүгэрсүрэн Сүхгэрэл**
Монголын “Оюу Толгойн Хяналт” Төрийн бус байгууллага, захирал

- **Мишель Форст**
НҮБ-ын Аархусын конвенцын
Байгаль орчныг хамгаалах асуудал
хариуцсан Тусгай илтгэгч
- **Виктор Мадригал-Борлоз**
Элеонор Рузвельт Харвардын
Хуулийн сургуулийн Хүний эрхийн
хөтөлбөрийн ахлах зочин судлаач,
Бэлгийн чиг баримжаа ба
жендэрийн баримжаа судлалын
НҮБ-ын бие даасан шинжээч асан
- **Наматай Квеквеза**
Идэвхтэн, Феминист, WELEAD Trust
захирал
- **Вринда Гровер**
Энэтхэгийн Дээд Шүүхэд
дадлагажигч хуульч, хүний эрхийн
төлөө тэмцэгч, НҮБ-ын Украины
асуудлаарх комиссын комиссар
- **Ольга Абраменко**
ADC Memorial шинжээч
- **Весам Ахмед**
Олон улсын эрх зүйн Хэрэглээний
Төвийн захирал, Аль-Хак
- **Отто Саки**
Форд Санг, Иргэний оролцоо болон
Засаглалын баг, Глобал
хөтөлбөрийн ажилтан
- **Йосра Султан**
Баруун Өмнөд Ази, Хойд Африк
дахь эмэгтэй хүний эрх
хамгаалагчдын бүс нутгийн
эвслийн гүйцэтгэх захирал
- **Пепе Жулиан Онзиема**
Угандагийн Бэлгийн цөөнх,
хөтөлбөрийн захирал

УДИРТГАЛ

Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах, үр дүнтэй хэрэгжүүлэхэд хүний эрхийг хамгаалагчдын **чухал үүргийг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;**

Хүний эрх хамгаалагчдын ажил, үйл ажиллагааг **үнэлж, дэмждэг соёлыг** тэтгэх, орчныг бүрдүүлэх, тэдний **шударга ёс, хүний нэр төр, хууль дээдлэх ёсыг бэхжүүлэхэд** оруулах хувь нэмрийг ухамсарлаж, хүлээн зөвшөөрөхийн чухлыг **ДАХИН НОТОЛЖ,**

Арьс үндсээр ялгаварлан гадуурхах, эцгийн эрхт ёс, гетеронормативизм, капитализм, популизм, неолиберализм, зэвсэгт мөргөлдөөн, эзлэн түрэмгийлэл, байгаль орчны хямрал, колоничлолын зэрэг хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааны **агуулгыг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;**

Эрх болон **хариуцлагыг** хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж буй ялгаварлан гадуурхалт, мөрдөн мөшгөх, эх орноосоо хөөгдсөн, амь насаараа хохирсон хүний эрх хамгаалагчидтай **эв санааны нэгдлээ ИЛЭРХИЙЛЭН;**

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглал, НҮБ-ын Нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хувь хүн, нийгмийн нэгж, байгууллагын эрх, үүргийн тунхаглал (Хүний эрх хамгаалагчийн тухай тунхаглал) Тунхаглалын **үндсэн үүргийг ОНЦОЛЖ;**

Тунхаглал нь зөвхөн улс орнууд болон хүний эрх хамгаалагчдыг уриалаад зогсохгүй хүн бүрийг **хамарсан** үйл ажиллагааны уриалгыг илэрхийлсэн хүний эрхийн талаарх дэлхий нийтийн ойлголт, амлалтад гарсан **үзэл санааны өөрчлөлтийг** илэрхийлж байгааг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ;**

Тунхаглалд заасан зарчмуудыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зарим бүс нутаг, улс орнуудад **ахиц дэвшил** гарсныг **САНАЖ,** эдгээр амжилт нь Тунхаглалын зорилтуудыг **бүрэн хэрэгжүүлэхэд** зайлшгүй шаардлагатай алхам болохыг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХИЙН ЗЭРЭГЦЭЭ** хүний эрх хамгаалагчдыг үр дүнтэй хамгаалах, чадавхжуулахад зайлшгүй шаардлагатай Тунхаглалыг иж бүрэн хэрэгжүүлэх, сайтар мониторинг хийх талаар **цоорхой** байсаар байгааг **ТЭМДЭГЛЭЖ;**

Олон улсын, бүс нутгийн болон үндэсний түвшинд хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх, хамгаалах талаарх хууль тогтоомж, стандарт, хууль зүйн шинжлэх ухаанд зарим **дэвшил гарсныг САЙШААЖ;**

Тунхаглалд хүний зарим эрхийг хангалттай тусгаагүй бөгөөд эдгээр цоорхойг **дигитал аюул заналхийлэл, гутаан доромжлох** болон **мөрдөн мөшгөх** зэрэг хүний эрх хамгаалагчдын өмнө тулгарч буй **шинэ болон шинэ тутам бий болж буй сорилт, саад бэрхшээлүүд** өсөн нэмэгдэж байгаа; хүний эрх хамгаалагчид өөрийн хувийн шинж байдал, эсхүл тодорхой асуудлаар хэрэгжүүлсэн ажил, үйл ажиллагаанаас үүдэн тулгарч буй **өвөрмөц эрсдэлүүд;** төрийн бус оролцогчид (түүний дотор бизнесийн байгууллага)-ын нөлөөлөл; үндэсний, бүс нутгийн, олон улсын түвшний иргэний нийгмийн хязгаарлалт, дарангуйлал улам **даамжруулж** байгааг **ТЭМДЭГЛЭН;**

Тунхаглалд тусгагдсан мөн чанар, зарчмуудыг олон тооны улс үл тоомсорлож байгаад **ТҮГШИЖ**, хүний эрх хамгаалагчдын эсрэг аюулгүй байдлын хүчнийхний үйлдэж буй халдлага, шүүхийн дарамт, гэмт хэрэгт тооцох шүүх эрх мэдлийн байгууллагын гүйцэтгэж буй үүрэгт **САНАА ЗОВНИЖ**, хүний эрх хамгаалагчдын үнэлж баршгүй хүчин чармайлтыг үгүй хийхэд чиглэсэн төрийн албан тушаалтнуудын хоосон үгээс **БЭРХШЭЭЖ**;

Хүний эрх хамгаалагчдад тулгарч буй байнгын **томоохон сорилт**, аюул заналхийлэл болон аллага, бие махбодын хүчирхийлэл, гутаан доромжлох, гэмт хэрэгт тооцох, ажил, үйл ажиллагаа явуулах боломж, хууль ёсны байдал, аюулгүй байдал, эрх чөлөөг алдагдуулсан **онлайн** болон **офлайн** бусад халдлага тогтмол үйлдэгдэж байгаад **ГҮНЭЭ САНАА ЗОВНИЖ**;

Хүний эрх хамгаалагчдын эсрэг үйлдсэн бүхий л заналхийлэл, халдлагыг **мөрдөн шалгах**, төрийн болон төрийн бус оролцогчид (түүний дотор бизнесийн байгууллагууд) үйлдсэн эсэхээс үл хамааран **хариуцлага хүлээлгэх, ял завших** асуудлыг авч үзэхийн амин чухал ач холбогдлыг **ОНЦОЛЖ**;

Хүний эрх хамгаалагчдын **олон янз байдал**, тэдний хувийн шинж байдал, ажил, үйл ажиллагааны мөн чанар нөлөөлсөн **ялгаа** болон **огтлолцсон эрсдэлийг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**, тэдэнд тухайлан чиглэсэн **хамгаалалтын арга хэмжээ, дэмжлэг** үзүүлэх шаардлагыг **ОНЦОЛЖ**;

Эмэгтэй хүний эрх хамгаалагчдын үүрэг, оруулж буй хувь нэмрийг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**, тэдэнд тулгарч байгаа жендэрт суурилсан хүчирхийлэл, арьс үндэс, нас, шашин шүтлэг, каст, үндэс угсаа, шилжилт хөдөлгөөний байдал, улс төрийн үзэл бодол, хөгжлийн бэрхшээлтэй байдал, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл, хүйсийн тодорхойломж, бусад хэлбэрийн ялгаварлан гадуурхалттай давхцан илүү ноцтой болдог **сорилт, эрсдэлд ГҮНЭЭ САНАА ЗОВНИЖ**;

Хүний эрх хамгаалагчдыг хүндэтгэх, дэмжих **төрийн бус оролцогчид** (түүний дотор бизнесийн байгууллагууд)-ын үүрэг хариуцлагыг **ЦОХОН ТЭМДЭГЛЭЖ**, хүний эрх хамгаалагчдын эсрэг халдлага, чухал ажил, үйл ажиллагааг үгүйсгэх, түүнд саад учруулахад тэдний **үүрэг өсөн нэмэгдэж** байгаад **ГҮНЭЭ САНАА ЗОВНИЖ**;

Байгаль орчин, уур амьсгалын хямрал, шударга шилжилт, хүн бүрд цэвэр, эрүүл, тогтвортой байгаль орчныг хангах чиглэлд хүний эрх хамгаалагчдын чухал **үүргийг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**;

Шинэ болон шинэ тутам гарч ирж буй технологийн хүний эрх хамгаалагчдад учруулж буй **аюул заналхийлэл**, цахим орчинд хүний эрхийг хэрэгжүүлэх, дэмжих боломжууд өргөжин тэлж байгааг болон хүний эрх хамгаалагчдын эрхийг **офлайн** болон **онлайн** орчинд хамгаалах шаардлагатайг **ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**;

Сүлжээ, эвсэл, хамтын нэгдэл болон нийгмийн бүлгүүд зэрэг хүний эрх хамгаалагчдыг хамтран хамгаалах хандлагын **ач холбогдлыг ОЙЛГОЖ**;

Олон улсын болон бүс нутгийн хүний эрхийн механизмууд, хүний эрхийн үндэсний байгууллагуудын хүний эрх хамгаалагчдыг **дэмжих**, тэдэнтэй **эв санааны нэгдэлтэй байхад** гүйцэтгэсэн **үүргийг САНАЖ**, хүний эрхийг хамгаалагчдыг илүү үр дүнтэй хамгаалахын тулд эдгээр механизмыг **бэхжүүлэх, зохих нөөцөөр хангах шаардлагатайг ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ**.

I БҮЛЭГ – ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ, ХӨХИҮЛЭН ДЭМЖИХ ЭРХИЙГ ТОДОРХОЙЛОХ, ДАХИН БАТЛАХ НЬ

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Хүний эрх хамгаалагчийн тодорхойлолт

Тайлбар: Тунхаглалын 1 дүгээр зүйлд хүний эрх хамгаалагчдыг хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг хөхиүлэн дэмжиж, хамгаалж, эсхүл дэмжих, хамгаалахаар зүтгэж байгаа хувь хүн, бүлэг хүмүүс гэж тодорхойлсон. Тунхаглалын бусад зүйлд хүний эрхийг дэмжих, хамгаалах, үйл ажиллагаа нь “тайван арга хэрэгслээр” дамжин илэрнэ (Тунхаглалын 12 (1), 12 (3), 13 дугаар зүйлийг үзнэ үү) гэж заасан нь хүний эрх хамгаалагчид хүчирхийлэл үйлдэх ёсгүй гэсэн утгатай. “Тайван арга хэрэгслээр” гэсэн нэр томъёог “хууль ёсны арга хэрэгслээр” гэсэнтэй адилтган ойлгож болохгүй, ялангуяа зарим дотоодын хууль тогтоомж нь дарангуйлсан шинжтэй бөгөөд олон улсын эрх зүйд нийцээгүй байдаг тул үйл ажиллагаа нь олон улсын эрх зүйн дагуу хууль ёсны хэдий ч үндэсний хууль тогтоомжид зааснаар хууль бус байх боломжтой гэсэн үг юм.

Энэхүү “Тунхаглал+25” дахь тодорхойлолт нь НҮБ-ын Тусгай илтгэгч (A/HRC/55/50 дэх бусад хэсгээс үзнэ үү) болон Америк хоорондын Хүний эрхийн шүүх (Америк хоорондын хүний эрхийн шүүхийн Колумбын эсрэг Хосе Алвеар Рестрепогийн хуульчдын хамтын нийгэмлэгийн гишүүдийн хүний нөөцийн хэсгээс дэлгэрүүлэн харна уу. Урьдчилсан татгалзал, Үндэслэл, Нөхөн төлбөр ба зардал, 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн шийдвэр, Цуврал C No 506, 473 дахь догол мөр) зэрэг хүний эрхийн мэргэжилтнүүдийн тодорхойлолтын утга санааг тусгасан.

Хүний эрх хамгаалагчийн статусыг аливаа хэлбэрээр бүртгүүлэх шаардлагагүй байх нь ихээхэн чухал юм.

“Тунхаглал +25”-д хэрэглэсэн утгаар “хүний эрх хамгаалагч” гэж хүний эрх, үндсэн эрх чөлөөг орон нутаг, улс, бүс нутаг, олон улсын түвшинд дангаараа болон бусад нийгмийн аливаа бүлэг, байгууллагатай хамтран хамгаалах, хэрэгжүүлэхийн тулд хөхиүлэн дэмжиж, хамгаалж байгаа эсхүл хамгаалах, хэрэгжүүлэхийг зорьж байгаа аливаа хувь хүнийг хэлнэ.

2 ДУГААР ЗҮЙЛ

Хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих эрхийг дахин батлах нь

Тайлбар: Энэхүү хэсэгт Тунхаглалд тусгагдсан олон тооны түгээмэл зарчмуудыг дахин батлав.

Улс орнууд хүний эрх, үндсэн эрх чөлөөг улс, бүс нутаг, олон улсын түвшинд хамгаалж, хэрэгжүүлэх эрх (цаашид “хүний эрх хамгаалах эрх” гэх)-ийг хүлээн зөвшөөрч, хамгаалж, хүндэтгэж, биелүүлнэ.

Улс орнууд хүний эрх хамгаалах эрхийг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, үзэл бодолтой байх түүнийгээ илэрхийлэх эрх чөлөө, эсэргүүцлийн тайван жагсаал, цуглаанд оролцох эрх, хүний эрхийн шинэ санаа боловсруулах, хэлэлцэх эрх, өөрийгөө тодорхойлох эрх, хувийн халдашгүй байх эрх, санхүүжилт хайх, хүлээн авах, ашиглах эрх, оролцох эрх, мэдээлэл олж авах эрх, олон улсын, бүс нутгийн хүний эрхийн байгууллагуудтай аюулгүй, саадгүй холбогдох, харилцах эрх зэрэг хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрч, хамгаалж, хүндэтгэн биелүүлнэ.

II БҮЛЭГ – ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДЫН ЭРХ, ТҮҮНИЙГ ХАМГААЛАХ НЬ

3 ДУГААР ЗҮЙЛ

Хүний эрх хамгаалах эрхийг хүлээн зөвшөөрөх

Тайлбар: Тунхаглалын удиртгал хэсэгт хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах хүний эрхийг хамгаалагчдын гүйцэтгэх чухал үүргийг хүлээн зөвшөөрсөн боловч Тунхаглалд хүний эрх хамгаалагчдын ажил, үйл ажиллагааг хүлээн зөвшөөрөх шаардлагыг улс орнуудад шууд тогтоогоогүй. Хүний эрх хамгаалагчдын ажил, үйл ажиллагааны үнэ цэнэ, хууль ёсны байдлыг хүлээн зөвшөөрөх нь тэднийг хамгаалах, таатай орчин бүрдүүлэхэд чухал хүчин зүйл болдог. Энэ талаар доорх заалтад тусгасан.

Хүний эрх хамгаалах эрхийн зөрчил, хүчирхийлэл нь хөхиүлэн дэмжиж, хамгаалагдсан хүний эрх, үндсэн эрх чөлөөний зөрчил, хүчирхийлэл мөн.

Улс орнууд хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах, хөхиүлэн дэмжих эрх, уг эрхийг эдэлж байгаа хүмүүсийн эрхийг ойлгон ухамсарлаж, бүх нийтээр хүлээн зөвшөөрнө.

Тухайлбал улс орнууд:

- (а) Хүний эрх хамгаалах эрхийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхийн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авбал зохино. Эдгээр нь төрийн өндөр албан тушаалтнууд олон нийтэд хандсан мэдэгдэл, хүний эрх хамгаалагчдыг дэмжих кампанит ажил, бусад арга хэмжээ, хүний эрх хамгаалагчдын ажил, үйл ажиллагааг боловсролын сургалтын хөтөлбөр, олон нийтийн хэлэлцүүлэгт тайлбарлаж, хүлээн зөвшөөрөх арга хэмжээ байж болно.
- (б) Шагналд нэр дэвшүүлэх, олон улсын форумд хүний эрх хамгаалагчдыг оролцуулах, олон улсын болон бүс нутгийн байгууллагуудад хүний эрхийг хамгаалагчдын ажил, үйл ажиллагааг сурталчлан таниулах зэргээр хүний эрх хамгаалагчдыг хүлээн зөвшөөрөх зорилго бүхий санаачилгыг дэмжвэл зохино.
- (в) Төрийн байгууллагуудад хүний эрх хамгаалах эрхийг хүндэтгэх, хамгаалах соёлыг тэтгэвэл зохино, түүний дотор хүний эрх хамгаалах эрх, уг эрхийг дангаараа болон хамтран хэрэгжүүлж байгаа хүний эрх хамгаалагчдын ажил, үйл ажиллагааны талаар хууль сахиулах, шүүхийн байгууллагын болон төрийн бусад албан хаагчдад зориулсан заавал суралцах сургалтын хөтөлбөрийг жендэрийн болон олон янз байдлын мэдрэмжтэй, уялдаа холбоог хангах хандлагыг баримтлан хэрэгжүүлнэ.
- (г) Хүний эрх хамгаалах эрх, уг эрхийг дангаараа болон бусадтай хамтран хэрэгжүүлж байгаа хүний эрх хамгаалагчдыг хүндэтгэх, дэмжихийн ач холбогдлын талаар төрийн албан хаагчдад ойлгомжтой удирдамж өгөх, тэдгээр удирдамжийг дагаж мөрдөөгүй албан тушаалтнуудад сахилгын арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлнэ.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Хүний эрх хамгаалах эрхийг хэрэгжүүлэх аюулгүй, таатай орчны эрх

Тайлбар: Аюулгүй, таатай орчинд үйл ажиллагаагаа явуулахад шаардлагатай үндсэн элементүүдийг хүний эрх хамгаалагчдын нөхцөл байдлын талаарх Тусгай илтгэгчийн 2013 оны 12 дугаар сарын илтгэлд (A/HRC/25/55) онцолсон. Хүний эрхийн Дээд Комиссарын Газар “Аюулгүй, таатай орчныг олон улсын эрх зүйд үндэслэсэн үндэсний хүчирхэг хууль зүйн тогтолцоогоор дэмжих ёстой” хэмээн гэж заасан. Үзэл бодолтой байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх, тайван хуран цуглах, төрийн үйл хэрэгт оролцох зэрэг эрх нь хүмүүсийг эерэг өөрчлөлтийн төлөө чиглүүлэх боломжийг олгодог эрхүүд юм. Хүн бүр дангаараа эсхүл бусадтай хамтран эдгээр эрхийг эдлэх ёстой” (Иргэний нийгмийн орон зай ба НҮБ-ын “Хүний эрхийн тогтолцоо: Иргэний нийгэмд зориулсан практикийн гарын авлага”-ыг үзнэ үү). НҮБ-ын Хүний эрх хамгаалагчийн асуудал хариуцсан Тусгай илтгэгч асан цааш нь хүний эрх хамгаалах эрхээ хэрэгжүүлснийхээ төлөө төрийн болон гуравдагч этгээдийн халдлагад өртөхгүй байх нь хүний эрхийг хүчирхийллээс хамгаалах төрийн үүрэг болохыг онцлон тэмдэглэсэн. Энэхүү үүргээ биелүүлэхийн тулд улс орнууд хүний эрх хамгаалах эрхийг хэрэгжүүлэх үндсэн эрхийг түүний дотор тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөө, үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, эсэргүүцэх эрх, санхүүжилт авах, хүний эрхийн талаар шинэ санаа боловсруулах, хэлэлцэх эрх болон тэдгээрийн эрх хамгаалагдсан байх, зөрчигдсөн эрхийг үр дүнтэй сэргээхийг дэмжсэн орчныг бэхжүүлэх шаардлагатай.

Улс орнууд хүний эрх хамгаалагчдын аюулгүй, таатай орчныг хангана.

Тухайлбал улс орнууд:

- (а) Хүний эрхийг дангаараа эсхүл бусадтай хамтран хамгаалах эрхийг хамгаалахад шаардлагатай тодорхой хууль, бодлогыг баталж, тэдгээр хууль, бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авна.
- (б) Хүний бүхий л эрх болон үндсэн эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, хамгаалах, биелүүлэх, үр дүнтэй хэрэгжүүлэх таатай хууль эрх зүй, институци, захиргааны тогтолцоог бүрдүүлж, хадгална.
- (в) Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдал, үйл ажиллагаатай нь холбоотойгоор болон хориглосон бусад үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг тусгайлан хориглосон иж бүрэн хууль тогтоомж, бодлогыг баталж, мөрдүүлнэ.
- (г) Төрийн бус оролцогчид (түүний дотор бизнесийн байгууллагууд) хүний эрх хамгаалах эрхийг хүндэтгэх, уг эрхийг зөрчсөн тохиолдолд тэдгээрт хариуцлага хүлээлгэх явдлыг хангасан хууль тогтоомж, бодлогыг батална.
- (д) Хүний эрх хамгаалах эрхийг хэрэгжүүлсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцсон, түүнд саад учруулсан, түүний дотор үзэл бодлоо илэрхийлэх, хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарласан, иргэний нийгмийн байгууллага

үүсгэн байгуулахыг хязгаарласан, аливаа байдлаар саад учруулсан, эсхүл Тунхаглал болон Тунхаглал+25-ын үзэл санаа, зорилгуудад бусад байдлаар харшлах аливаа хууль тогтоомж, бодлогыг батлах, хүчин төгөлдөр мөрдүүлэх, хэрэгжүүлэхээс татгалзана.

- (е) Үйлдэл, эс үйлдэхүйгээр хүний эрх хамгаалах эрхийг зөрчсөн төрийн албан тушаалтныг мөрдөн шалгах, ойлгомжтой заасан эрүүгийн болон захиргааны шийтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлэх явдлыг хангах.
- (ё) Хүний эрх хамгаалагчдын эсрэг аливаа аюул заналхийлэл, халдлагыг шуурхай, бүрэн гүйцэд, хараат бусаар, шударгаар мөрдөн шалгах явдлыг хангах, тэдний эсрэг зөрчил, хүчирхийлэл үйлдэгдсэн тохиолдолд шүүхэд хандах, зөрчигдсөн эрхийг нь сэргээх, хариуцлага хүлээлгэх баталгааг хангана.
- (ж) Хүний эрх, үндсэн эрх чөлөөний талаарх хууль, бодлогыг бий болгох, хэрэгжүүлэх, мониторинг хийхэд хүний эрх хамгаалагчдын идэвхтэй, утга учиртай оролцоог хангана.
- (з) Хүний эрх хамгаалагчдыг хамгаалах талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээ нь хүний эрх хамгаалах эрхийн хувь хүний болон хамтын хандлагын аль алиныг нь харгалзан үзсэн хууль тогтоомж, төрийн бодлогыг батлах зэргээр хүний эрх хамгаалах эрхийн таатай орчныг бүрдүүлэх баталгааг хангаж хүний эрх хамгаалагчдын хамтын хэрэгцээ шаардлагад нийцсэн байх явдлыг хангана.
- (и) Хүний эрх хамгаалагчидтай зөвшилцсөний үндсэн дээр эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдыг хамгаалах үр дүнтэй бодлого, механизмыг бий болгох, хадгалах, хангалттай нөөцөөр хангана.
- (к) Эмэгтэй хүний эрх хамгаалагчид болон эмэгтэйчүүдийн эрх, жендэрийн асуудлаар ажилладаг хүмүүст тулгарч буй эрсдэл, сорилтод онцгой анхаарал хандуулна.
- (л) Бүх хүмүүст олон улсын хүний эрхийн байгууллага, механизм, ажиллагаанд чөлөөтэй, аюулгүй, саадгүй хандах явдлыг хангана.

Түүнчлэн улс орнууд нь:

- (л) Хүний эрхийн үндэсний байгууллагуудыг Парисын зарчимд нийцүүлэн хүчирхэг, хараат бус, үр нөлөө бүхий хүний эрхийн үндэсний байгууллагуудыг бий болгох, хадгалах, зохих нөөцөөр хангана.
- (м) Хүний эрх хамгаалах эрхийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт, дэмжлэгийг бий болгоход улс төрийн дэмжлэг үзүүлж, шаардлагатай бүх арга хэмжээг авна.
- (н) Хүний бүх эрхийг аюулгүй, шийтгэлээс айхгүйгээр эдлэх, дэмжих, хамгаалах нээлттэй, чөлөөтэй, хүртээмжтэй цахим орчныг бий болгох, хадгалахад чиглэсэн хууль тогтоомж, бодлогыг батална.

Гутаан доромжлол, гэмт хэрэгт тооцохоос хамгаалах

Тайлбар: Хэлэлцүүлгийн тайлангуудад хүний эрх хамгаалагчдыг гутаан доромжлох, гэмт хэрэгт тооцох явдал эрс нэмэгдэж байгааг санал нэгтгэйгээр онцолж байна. Гутаан доромжлох нь ихэвчлэн гүтгэх, нэр төрийг гутаах кампанит ажил өрнүүлэх, хүний эрх хамгаалагчдыг нийтийн дайсан, террорист, гадаадын агент хэмээн цоллох, тэднийг нийгмээс тусгаарлах, тэдний эсрэг үйлдэгдсэн зөрчлийг цаашид хууль ёсны хэмээн үзэх зэргээр илэрдэг. Нөгөө талаар мөрдөн мөшгөх нь хүний эрх хамгаалагчдыг олон улсын хуулиар хамгаалагдсан ажил, үйл ажиллагааных нь төлөө эсхүл нотлогдоогүй бусад үндэслэлээр яллах, баривчлах зорилгоор эрх зүйн тогтолцоог урвуулан ашиглах хэлбэрээр явагддаг. Гэмт хэрэгт тооцох нь үндэслэлгүй захиргааны шаардлага тавих, хяналт шалгалт хийх, шийтгэл оногдуулах зэрэг мөн хамаарна. Гутаан доромжлох, гэмт хэрэгт тооцох нь ихэвчлэн мөчлөгөөр явагдаж нэг нь нөгөөгөө тэтгэж, даамжруулдаг. Ерөнхийдөө хүний эрх хамгаалагчдыг гутаан доромжлох нь тэдний үйл ажиллагааг гэмт хэрэгт тооцоход хууль зүйн тогтолцоог ашигладаг. Үүнтэй адилаар хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааг нэгэнт гэмт хэрэгт тооцсоны эцэст нийгэм тэднийг сөргөөр харж, энэ нь гутаан доромжлолт, хэл амаар болон бие махбодын дайралтад хүргэж болзошгүй юм.

Ерөнхийдөө гутаан доромжлох, гэмт хэрэгт тооцохын аль аль нь хүний эрхийг хамгаалагчдыг айлган сүрдүүлэх, дуугүй болгох тактик болж байна. Доорх заалтад Тунхаглалд үндэслэсэн гутаан доромжлох, гэмт хэрэгт тооцох асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн тогтолцоог санал болгохын тулд боловсруулав. Энэхүү заалт нь ялгаварлан гадуурхах асуудалд хамаарахгүй гэдгийг анхаарах нь зүйтэй, учир нь эдгээр асуудал нь Тунхаглалын 12.2-т нэгэнт тусгагдсан байдаг.

Улс орнууд хүний эрх хамгаалагчдыг гутаан доромжлох, гэмт хэрэгт тооцогдохоос ангид байдлаар ажил, үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлэхийн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Тухайлбал улс орнууд нь:

- (а) Төрийн болон төрийн бус оролцогчдын (үүнд: бизнесийн байгууллагуудыг оролцуулан) аль аль нь хүний эрх хамгаалагчдыг гутаан доромжлох, эсхүл олон улсын эрх зүйд харш аливаа байдлаар тэдний ажил, үйл ажиллагааг хязгаарлах явдлаас зайлсхийх, хориглох, шийтгэл хүлээлгэх. Үүнд: заналхийлэх, дарамтлах, айлган сүрдүүлэх, хүчирхийлэх, доромжлох, нэр төрийг гутаах, зүй бус нэр хоч зүүх, хүний эрх хамгаалагчдын ажил, үйл ажиллагааг гутаан доромжлоход чиглэсэн элдэв яриа тараах, тандаж мөшгөх, хүний эрх хамгаалах ажил, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлөх аливаа бусад хэлбэрийн үйл ажиллагаа явуулах зэрэг хамаарна.

- (б) Олон улсын эрх зүйд харш байдлаар үзэл бодлоо илэрхийлэх, эсэргүүцлийн тайван жагсаал хийх, хуран цуглах, эвлэлдэн нэгдэх, олон нийтийн оролцоо, хувийн халдашгүй байдлыг хязгаарлах зэргээр хүний эрхийг хамгаалах эрхийг гэмт хэрэгт тооцох, хязгаарлах, аливаа бусад байдлаар хязгаарласан хууль, бодлого, практикийг хүчингүй болгох буюу хэрэглэхийг зогсооно.
- (в) Үндэсний аюулгүй байдлыг хангах, терроризмтой тэмцэхэд чиглэсэн хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагаа нь тодорхой, дур зоргын бус, хэт өргөн хүрээтэй бус бөгөөд олон улсын эрх зүйд харш байдлаар хүний эрх хамгаалах эрхийг гэмт хэрэгт тооцох, бусад хэлбэрээр хязгаарлахгүй байх явдлыг хангана.
- (г) Бүх шатны төрийн байгууллага, албан тушаалтнууд бүх салбарт хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах хүчин чармайлтыг өөрсдийн үйлдэл, эс үйлдэхгүйгээр гутаан доромжлохгүй байх, хууль ёсны байдлыг алдагдуулахгүй байх явдлыг хангана.
- д) Хүний эрх хамгаалах эрхээ эдэлж буй хүмүүст тэдний эсрэг чиглэсэн гутаан доромжлох аливаа үйлдлээс хамгаалалт хүсэх, зөрчигдсөн эрхээ сэргээлгэхэд нь хууль зүйн мэргэшсэн үйлчилгээ авах замаар шүүхэд шуурхай бөгөөд саадгүй хандах боломжийг хангана.

Үүнээс гадна улс орнууд:

- (е) Хүний эрх хамгаалагчид тэдгээрийн гэр бүл болон бүлгийн эсрэг бүх хэлбэрийн гутаан доромжлол, халдлагыг хоёрдмол утгагүйгээр буруутгах;
- (ё) Төрийн болон төрийн бус оролцогчдод (үүнд бизнесийн байгууллагуудыг оролцуулан) Олон нийтийн оролцооны эсрэг стратегийн нэхэмжлэл (ОНОЭСН) ашиглахыг хориглох, ОНОЭСН-ийн эсрэг хууль тогтоомж батлах зэргээр хүний эрх, үндсэн эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, үр дүнтэй хэрэгжүүлэх үйл ажиллагааг хязгаарлахыг хориглоно.

6 ДУГААР ЗҮЙЛ

Эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдал, хамгаалалт

Тайлбар: Энэхүү “Тунхаглал+25”-ыг боловсруулах явцад хүний эрх хамгаалагчидтай хийсэн зөвлөлдөх уулзалтын тайланд хүний эрх хамгаалагчдын хувийн шинж байдал (үүнд: эмэгтэйчүүд, хүүхдүүд, уугуул хүмүүс эсвэл Африк гаралтай хүмүүс) болон тодорхой асуудлаар явуулж байгаа ажил, үйл ажиллагаа (уур амьсгал, арьс үндэс, нийгмийн шударга ёс, жендэрийн тэгш байдал, уугуул хүмүүсийн эрх, цөөнхийн эрх)-наас үүдэн эрсдэлд өртөмтгий, эмзэг байдал өсөн нэмэгдэж байгааг онцолсон. Мөн хүний эрх хамгаалагчид арьс үндсээр ялгаварлан гадуурхах үзэл, патриарх, гетеронормативизм, капитализм, эзлэн түрэмгийлэл, дарангуйллын бусад давхраа зэрэг бүтцийн тогтолцоо нь тэднийг онцгой эрсдэлд оруулж байгааг мэдээлсэн. Түүнчлэн

хүний эрх хамгаалагчид үндсэн эрх, эрх чөлөө болох хуран цуглах, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөгөө хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус оролцогчдын зүгээс үлэмж саад тотгорттой тулгардаг. Төрийн байгууллагууд дарангуй хууль тогтоомж, дур зоргоор цагдан хорих болон хуран цуглах, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлахад чиглэсэн бодлогоор хүний эрх хамгаалагчдын ажил, үйл ажиллагаанд эрх зүйн болон биет саад тотгор олонтоо учруулдаг. Төрийн бус оролцогчид тэдгээрийн дунд бизнесийн байгууллагууд дарамтлах, айлган сүрдүүлэх, ОНОЭСН гаргах, хүний эрх хамгаалагчдын эсрэг бусад хэлбэрийн хүчирхийлэл үйлдэж болно. Доорх заалтын зорилго нь эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчид өсөн нэмэгдэж байгаа эрсдэлд тохирсон хамгаалалт эдлэх явдлыг хангах, түүнчлэн хамгаалалтын зорилго нь эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдлыг хангахаас гадна хүн бүрийн эрхийг хамгаалах эрхийг баталгаатай болгох тогтвортой, бүтцийн өөрчлөлтөд хүрэх явдал учир урьдчилан сэргийлэх хандлагатай болно.

- (1) Улс орнууд бүх хүний эрх хамгаалагчид, ялангуяа эрсдэлд байгаа эсхүл цагдан хоригдсон, хүчирхийлэл, заналхийлэл, өс хонзонгийн хохирогч болсон, хориглосон ялгаварлан гадуурхалт, дарамт шахалт, санаатай буюу байнгын гадуурхалт, дарангуйлал, төрийн болон төрийн бус оролцогчид (үүнд: бизнесийн байгууллага оролцуулан) бусад хэлбэрийн сөрөг үр дагаварт дараах шалтгаанаас хамааран өртсөн хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдал, хамгаалалтыг хүлээн зөвшөөрөх, түүнд тэргүүлэх ач холбогдол өгөх, хамгаалах. Үүнд:
 - (а) Нас, хүйс, бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа, илэрхийлэл, хүйсийн тодорхойломж, арьсны өнгө, каст, хөгжлийн бэрхшээлтэй байдал, хэл, шашин шүтлэг, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, газарзүйн байршил, үндэстний цөөнх, уугуул хүмүүст харьяалагдах байдал, өмч хөрөнгө, төрөлт, шилжилт хөдөлгөөний байдал, эсхүл хүний эрх хамгаалагчийн байдал;
 - (б) Онлайн болон офлайн харилцаа холбоо, сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн ажил, хууль зүйн ажил зэрэг хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр тэдгээрийн ажил, үйл ажиллагаа;
 - (в) Эмэгтэйчүүд, жендэрийн эрх, ЛГБТКИ+ эрх; уур амьсгалын шударга ёс, газрын ба байгаль орчны эрх; цахим орчин дахь эрх; уугуул хүмүүсийн эрх; шашин шүтлэг, итгэл үнэмшлийн эрх чөлөө; эзлэн түрэмгийлэл, колониолол, неоколониололын эсрэг; арьс үндсээр алагчлах үзэл; бизнес ба хүний эрх; ял завших, хариуцлага, зөрчигдсөн эрхийг сэргээх; авлига; сонгууль; зэвсэгт мөргөлдөөн; шилжилт хөдөлгөөн, албадан нүүлгэлт, шилжүүлэлт зэрэг тэдний ажиллаж байгаа асуудал, орчин;
- (2) Улс орнууд эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдал, хамгаалалтыг хангахад хамтын болон салбар хоорондын уялдаа холбоог бий болгоно. Энэхүү хандлага нь хүний эрх хамгаалагчийн хувийн шинж байдал, ажил, үйл ажиллагаа, тэдгээрийн ажиллаж байгаа асуудал, орчин нь ялгаварлан гадуурхалт, эрсдэлийг нэмэгдүүлж, зорилтот хамгаалалтын стратегийг зайлшгүй шаардаж байгааг хүлээн зөвшөөрвөл зохино. Энэхүү хандлагыг аливаа урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээнд хэрэглэвэл зохино.

- (3) Улс орнууд эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдал, хамгаалалтыг хангахын тулд урьдчилан сэргийлэх, хариу үйлдэл үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
- (а) Хүний эрх хамгаалах эрхээ эдэлснийхээ төлөө цагдан хоригдсон хүмүүсийн хэргийн шүүхийн ажиллагааг түргэвчлэх эсхүл суллах, тэдний ажил, үйл ажиллагаанаас үүдсэн хүний эрх хамгаалагчдын эсрэг бүх хэлбэрийн дарамт шахалт, сөрөг бусад арга хэмжээг таслан зогсооно.
 - (б) Тунхаглал болон Тунхаглал+25-д дурдсан хүний эрх, үндсэн эрх чөлөөг төрийн бус оролцогчид (бизнесийн байгууллагуудыг оролцуулан) зөрчсөн тохиолдолд зөрчигдсөн эрхийг сэргээх тодорхой журам бүхий хүний эрх хамгаалагчдын хамгаалалтыг хэрэгжүүлж, мөрдүүлэх явдлыг хангана.

7 ДУГААР ЗҮЙЛ

Эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдын иж бүрэн хамгаалалт

Тайлбар: Хүний эрхийн нөлөөллийн үйл ажиллагаа нь ихэвчлэн өндөр стресс, эрсдэл, өртөмтгий нөхцөлд явагддаг. Гэвч Тунхаглалд энэ талаар тусгасан тодорхой заалт байхгүй байна. Энэхүү Тунхаглалыг боловсруулах явцад хүний эрх хамгаалагчидтай хийсэн зөвлөлдөх уулзалтын нэгдсэн тайланд сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэц-нийгмийн үр дагавар нь хүний эрх хамгаалагчдад тулгардаг хамгийн түгээмэл сорилтуудын нэг болохыг баримтжуулсан.

Улс орнууд хүний эрх хамгаалагчид ажил, үйл ажиллагаа явуулахдаа заналхийлэл, хүчирхийлэл, гутаан доромжлол, бусад сорилтуудтай тулгардаг үлэмж эрсдэлийг хүлээн зөвшөөрөх ёстой. Эдгээр бодит байдлын үүднээс энэхүү заалтад хүний эрх хамгаалагчдын бие махбод, сэтгэц-нийгмийн болон цахим орчны найдвартай, аюулгүй байдлыг хамарсан иж бүрэн хамгаалалтыг улс орнууд хангах шаардлагатай болохыг онцлон тэмдэглэж байна. Энэ нь тэдний бие махбодын аюулгүй байдлыг хамгаалахаас гадна эрүүл мэнд, хууль зүйн эрх, нийгэм-эдийн засгийн сайн сайхан байдлыг багтаасан ерөнхий сайн сайхан байдалд анхаарал хандуулахыг шаардаж байна.

Улс орнууд хүний эрх хамгаалагчид тэдний бүлгийн иж бүрэн хамгаалалтыг хангах, тэдэнд ажил, үйл ажиллагаагаа дангаараа болон хамтран үргэлжлүүлэх бололцоог бүрдүүлэхийн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Улс орнууд хүний эрх хамгаалагчдын эрхийг хүндэтгэхэд чиглэсэн төрийн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлэх; тэдний эрхийг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх; тэдгээрийн эсрэг үйлдсэн зөрчил, хүчирхийллийг сайтар мөрдөн шалгах; хүний эрх хамгаалагчдын эсрэг аливаа халдлагын гүйцэтгэгч, зохион байгуулагчдад хариуцлага хүлээлгэх явдлыг хангана.

Эдгээр арга хэмжээг хэрэгжүүлэхдээ улс орнууд нөлөөлөлд өртсөн хүний эрх хамгаалагчид болон бүлгүүдтэй хэлэлцэн зөвшөөрсний үндсэн дээр:

- (а) Хүний нэр төрийг дэмжих, хүний эрх, үндсэн эрх чөлөө болон хувь хүн, байгууллагын бие даасан байдлыг хүндэтгэх хүрээнд хүний эрх хамгаалагчдын бие махбодын хамгаалалт, дижитал цахим орчин дахь аюулгүй байдлын талаар үр дүнтэй арга хэмжээ авна.
- (б) Аюул ослоос амьд үлдсэн эсвэл өөрсдийн ажлаас үүдсэн удаан хугацааны хүнд хэлбэрийн ужиг стресст өртсөн хүний эрх хамгаалагчдын бие махбодын болон сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн тусламж, нийгмийн дэмжлэг үзүүлэх замаар эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хөхиүлэн дэмжих. Энэхүү дэмжлэг нь хүний эрх хамгаалагчдын онцлог хэрэгцээг харгалзан үзсэн, хүртээмжтэй, нууцлалтай, соёлын хувьд зохистой, ялгаварлан гадуурхаагүй байх ёстой.
- (в) Хүний эрх хамгаалагчдад тулгардаг эрсдэлийг бий болгож байгаа эсвэл нэмэгдүүлж байгаа бүтцийн нөхцөлүүд тухайлбал ял завших, хариуцлага хүлээхгүй байх, улс төрийн тогтворгүй байдал, үүнд цэрэгжилт, онц байдал, экстремизм, аливаа хэлбэрийн байнгын ялгаварлан гадуурхалт, улс дамнасан дарангуйллын талаар үр дүнтэй арга хэмжээ авна.
- (г) Хүний эрх хамгаалагчдад онц байдлын болон шуурхай хариу арга хэмжээ авах механизмыг бий болгох, хэвээр байлгах, тэдгээрт зориулсан зохистой нөөц бий болгохыг дэмжинэ.
- (д) Хараат бус, шударга шүүн таслах ажиллагааны хүртээмжийг хангах, хүний эрх хамгаалах ажил, үйл ажиллагаатай нь холбоотойгоор үүсгэгдсэн эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль зүйн туслалцаа үзүүлэх. Түүнчлэн улс орнууд хувь хүмүүс төлбөрийн чадваргүй, тухайлбал хүний эрх хамгаалах эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой хэргүүдэд хууль зүйн туслалцаа үзүүлнэ.
- (е) Хүний эрх хамгаалагчдын эсрэг үйлдэгдсэн хүний эрхийн зөрчил, хүчирхийлэлтэй холбогдуулан үнэн зөвийг тогтоох, хохирол нөхөн төлүүлэх, дахин давтагдахгүй байх арга хэмжээг хэрэгжүүлэх явдлыг хангаж хүний эрх хамгаалагчид, тэдний бүлгүүдийн эсрэг аливаа халдлага үйлдсэн төрийн болон төрийн бус аливаа оролцогчдыг мөрдөн шалгах, яллах, шийтгэх зохих арга хэмжээг авна.
- (ё) Таатай бус орчин, алслагдсан бүс нутаг, хөдөө орон нутагт хүний эрх хамгаалагчдыг үр дүнтэй, найдвартай хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд үндэсний болон орон нутгийн засаг захиргааны хамтын ажиллагааг хангана.

8 ДУГААР ЗҮЙЛ

Хүний эрх хамгаалагчдын гэр бүл, төрөл садан, хамтран зүтгэгч, төлөөлөгч, бүлгийг хамгаалах

Тайлбар: Энэхүү заалт нь хүний эрх хамгаалагчдын хүлээн зөвшөөрөгдсөн хамгаалалтыг тэдний гэр бүл, төрөл садан, хамтран зүтгэгч, төлөөлөгч, бүлэгт нь хамааруулж өргөжүүлэх зорилготой. Учир нь тэдгээр хүмүүс нь хүний эрх хамгаалагчидтай харилцаатай байдаг шинжээрээ олон төрлийн ноцтой сөрөг үр дагавартай тулгардаг. “Тунхаглал+25” нь “гэр бүл”, “төрөл төрөгсөд”, “хамтран зүтгэгч”, “төлөөлөгчид”, “бүлэг” гэсэн нэр томъёог тодорхойлохыг зориогүй. Эдгээр нэр томъёог гэр бүл, нийгмийн зохион байгуулалтын өргөн хүрээг хамруулах өргөн агуулгаар тайлбарлах шаардлагатай. Тухайлбал “гэр бүл”-ийг өргөн хүрээнд тайлбарлахдаа уламжлалт бус гэр бүлийн нэгж, гэрлээгүй хамтрагчид, сонгосон гэр бүлүүдийг хамруулан ойлгоно.

Улс орнууд Тунхаглал болон Тунхаглалд+25-д заасан хүний эрх хамгаалагчдыг хамгаалах, дэмжих баталгааг дараах байдлаар өргөжүүлэх явдлыг хангана.

- (а) Төрөл садан, тэдний гэр бүлийн гишүүд;
- (б) Мэргэжлийн болон бусад холбоотой хамтран ажиллагсад, төлөөлөгчид, үүнд хууль ёсны төлөөлөгчид;
- (в) Хүний эрх хамгаалагчидтай холбоо хамааралтай эсвэл дэмжлэг үзүүлдгийн улмаас зөрчил, хүчирхийлэл, сөрөг бусад үйлдэлд өртөж болзошгүй бүлгүүд.

9 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХХТ)-ийн хүртээмж, технологиор дөхөм болсон хүний эрхийн зөрчлийн шинэ болон шинээр үүсэж буй хэлбэрээс хамгаалах

Тайлбар: МХХТ нь хүний эрх, үндсэн эрх чөлөөг хөхиүлэн дэмжих, хамгаалах, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй.

Хүний эрх хамгаалагчид (а) интернэт, гар утасны сүлжээг ашиглахдаа цахим гэмт хэрэг, (б) сошиал орчинд тусгайлан чиглэсэн хүчирхийлэл, дарамт, худал мэдээлэл, ташаа болон алдаатай мэдээлэл тараах хэлбэрийн, (в) хор хөнөөлт программ хангамж, тагнуулын программ хангамж, техникийн бусад халдлагын цахим аюулгүй байдлын эмзэг байдал, (д) зорилтот болон масс тандалт, хуурамч, болон хорлонтойгоор үүсгэсэн синтетик мэдээлэлд өртөх нь нэмэгдсээр байна.

Тэдний халдашгүй байдал, мэдээллээ хамгаалуулах үндсэн эрх нь ихэвчлэн мөшгөх арга хэрэгсэл, шифрлэлтийн стандартыг сулруулах, нэр нууцлахыг албадан таних, нэрээ нууцлахыг нь хууль бус болгох, харилцаа холбоо, мэдээллийн хяналтын улмаас зөрчигдөх нь олонтоо тохиолдож байна.

1998 онд Тунхаглалыг баталснаас хойш технологийн хурдацтай хувьсал, ухаалаг утас, сошиал медиа өргөн тархсантай холбоотойгоор үүссэн эдгээр сорилт, бэрхшээлийг Тунхаглалд авч үзээгүй. Технологи нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад хүний эрх хамгаалагчдыг хүчирхэгжүүлэхэд тусалдаг хэдий ч шинэ эмзэг байдлыг бий болгосон. Улс орнууд тэдгээрийн хууль сахиулах байгууллагууд (ихэвчлэн төрийн бус бусад оролцогчдын түүний дотор бизнесийн байгууллагуудын тусламжтайгаар) сошиал медиа, бусад платформ дээр хүний эрх хамгаалагчдын хуваалцсан мэдээллийг ихэвчлэн устгах эсвэл агуулгыг хянадаг. Цахим технологи нь хүний эрх хамгаалагчдын хувийн мэдээлэл, тэдгээрийн хаана байгаа, үйл ажиллагаа, сүлжээ зэргийг ил болгож, мэдээлэл алдагдах, цахим ул мөр, шууд тандалт, мэдээллийг замаас нь барих, хянах зэрэгт өртөмтгий болгодог. Хүний эрх хамгаалагчид нь айлган сүрдүүлэлт, дарамт, гүтгэлэг, цахим орчны гүтгэлэгт ихээр өртөж байна.

Эдгээр платформыг үзэн ядсан яриаг түгээх, хүний эрх хамгаалагчдын эсрэг шинэ хэлбэрийн зөрчил, хүчирхийлэл үйлдэх, тэр дундаа эмэгтэй хүний эрх хамгаалагчдын эсрэг онцлог хэлбэр болгон ашиглаж байна. Жишээлбэл сошиал медиа платформыг заримдаа хүний эрх хамгаалагчдын эсрэг суртал ухуулга явуулах, тэдгээрийг мөрдөн мөшгөхөд урвуулан ашигладаг. Хүний эрх хамгаалагчдын хувийн мэдээллийг цахим орчинд ил болгох, зүй бус нэр, хоч зүүлгэх, гутаан доромжлох, гүтгэх кампанит ажил өрнүүлэх замаар сошиал медиа платформд онилдог. Шүүхүүд олон нийтийн оролцооны эсрэг стратегийн нэхэмжлэлийг (ОНОЭСН) зөвшөөрч, мэдээлэл цуглуулах, жиргэх, нийтийн ашиг сонирхлын үүднээс мэдээлэл хуваалцах зэрэг хууль ёсны онлайн үйл ажиллагаанд иргэний болон эрүүгийн хатуу шийтгэл ногдуулдаг.

Доорх заалт нь хүний эрх хамгаалагчдыг үйл ажиллагааныхаа хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологи, түүний дотор шифрлэлт зэрэг техникийн шийдлүүдийн эрсдэлд орохгүйгээр ашиглах боломжийг хангахад чиглэсэн болно. Мөн хүний эрх хамгаалагчдын мэдээлэл олж авах, интернэт, гар утасны сүлжээ зэрэг нээлттэй, найдвартай, хямд үнээр мэдээлэл харилцаа холбооны технологи ашиглах эрхийг дахин онцолж байна.

Улс орнууд хүний эрх хамгаалагчдын бүх нийтийн, боломжийн үнэтэй, нээлттэй, найдвартай, харилцан үйлчлэх боломжтой, аюулгүй, мэдээлэл болон харилцаа холбооны технологийг бүрэн, тэгш хүртэх эрхийг хамгаалахад чиглэсэн хууль, бодлогыг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх замаар хүний эрх хамгаалах эрхийг бэхжүүлбэл зохино. Үүнд: болох шифрлэлт, зохиомол нэршил ашиглах, нэрээ нууцлах зэрэг цахим харилцааны нууцлалын аюулгүй байдлыг хангаж хамгаалах техникийн шийдлүүд багтана. Улс орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хувийн халдашгүй байдлыг хамгаалах хууль болон бодлогын, болон бусад арга хэмжээг баталж, цахим дарамтын бүх хэлбэрээс түүний дотор технологийн дэмжлэгтэй жендэртэй холбоотой хүчирхийллээс хамгаалах явдлыг хангана. Улс орнууд өөрсдөө эсхүл тэдний итгэмжлэн эрх олгосон этгээдүүд ийм зөрчил, хүчирхийллийн буруутан байх нь олонтоо тохиолддог учир тэд цахим орчинд хүний эрхийг хамгаалж, хэрэгжүүлэх баталгааг хангах ёстой.

Улс орнууд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хэрэгжүүлэхэд мөн Тунхаглал болон Тунхаглал+25-д тусгагдсан эрхийг хэрэгжүүлэхэд цахим орон зай, хэрэгслүүд үлэмж хүч чадал олгож байгааг хүлээн зөвшөөрвөл зохино.

Тухайлбал улс орнууд нь:

- (а) Хүний эрх хамгаалагчдыг ялгаварлан гадуурхахгүйгээр, ямар ч нөхцөлд тэр дундаа онц байдлын үед бүх нийтээр, боломжийн үнэтэй, нээлттэй, найдвартай, харилцан үйлчлэх боломжтой, аюулгүйгээр мэдээлэл, харилцаа холбооны технологийн бүрэн, тэгш хүртээмжтэй байх явдлыг хангана.
- (б) Сонгууль, эсэргүүцлийн жагсаал, дайн, хүмүүнлэгийн хямрал зэрэг ямар ч үед интернэтийг хаах, шугамыг хязгаарлах, цахим харилцаа холбоог санаатайгаар таслах, нэвтрэх боломжийг хязгаарлахгүй.
- (в) Хувь хүний мэдээлэл, дижитал харилцааны нууцлалыг хүлээн зөвшөөрч хамгаалсан хууль тогтоомж, бодлогыг батлах. Улс орнууд хүний эрх хамгаалагчдын техникийн шийдлийг ашиглах, тухайлбал шифрлэх, зохиомол нэр ашиглах, нэрээ нууцлах зэрэг арга хэмжээг олон улсын хүний эрхийн хууль тогтоомжид нийцсэн аливаа хязгаарлалттайгаар ашиглахад хөндлөнгөөс оролцохгүй.
- (г) Технологийн дэмжлэгтэй жендэрт суурилсан хүчирхийлэл, нэр төрийг гутаах кампанит ажил, хүний эрх хамгаалагчдын хувийн мэдээллийг цахим орчинд ил болгох, хортой болон хуурамчаар үүсгэгдсэн мэдээллийг тараах, хүний эрх хамгаалагчдын эсрэг бусад аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх хувийн хэвшлийн оролцогчдод хариуцлага хүлээлгэх явдлыг хангах зэргээр шаардлагатай хууль тогтоох, захиргааны, техникийн болон бусад арга хэмжээг авна. Үүнд: төр өөрөө, эсхүл түүний итгэмжлэгдсэн этгээдүүд дарамт үйлдсэн тохиолдлууд хамаарна.
- (д) Олон улсын хүний эрхийн эрх зүйд харшлахгүйгээр ашиглах боломжгүй, эсхүл эрсдэлд байгаа хүмүүсийн, түүний дотор хүний эрх хамгаалагчдын хүний эрхийг хэрэгжүүлэхэд хэт эрсдэл учруулж болзошгүй хиймэл оюун ухааны системүүд, шинээр бий болж буй бусад технологиос татгалзах, ашиглахыг зогсооно.
- (е) Хүний эрхийн хамгаалалт бий болгох хүртэл тандалтын технологийг худалдах, экспортлох, шилжүүлэх, ашиглахыг хориглоно. Үүнд: олон нийтийг хамарсан тандалт, ялгаварлан гадуурхсан зорилтод тандалтыг хэрэгжүүлэх боломжийг олгодог нүүр царай таних болон алсын биометрийн таних технологи түүний дотор хүний нэр төрийг хүндэтгэдэггүй, зориулалтаараа хүний эрхийг зөрчих хүний сэтгэл хөдлөлийг таних, хүйс таних технологийг хамааруулна.
- (г) Бизнесийн байгууллагууд болон төрийн байгууллагуудын цуглуулж, хадгалж, боловсруулж, дүн шинжилгээ хийсэн эсхүл бусад хэлбэрээр ашигладаг аливаа хувийн мэдээлэлтэй хүний эрхэд нийцсэн байдлаар харьцах, өөрт нь хамаарах мэдээллийг хэрхэн ашигладаг талаар мэдлэгтэйгээр сонголт хийх боломжийг хувь хүмүүст олгох, өгөгдөлтэй зөвшөөрөлгүй танилцах, урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэх явдлыг хангана.

Үүнээс гадна улс орнууд:

- (ж) Төрийн үйлчилгээг авах, нийгмийн амьдралд оролцохын тулд хувь хүмүүсийг цахимд холбогдохыг албадахгүй байх, цахим орон зайд холбогдохгүй байх эрхийг нь хүндэтгэнэ.
- (и) Хиймэл оюун ухааны систем, шинээр гарч ирж буй бусад технологиудыг олон улсын хүний эрхийн эрх зүйд нийцүүлэн ашиглах явдлыг хангах, хүний эрх хамгаалагч зэрэг эрсдэлд байгаа хүмүүсийн эрхийг хангахад хэт эрсдэл учруулах технологийг ашиглахаас татгалзах буюу ашиглахыг зогсооно.
- (ж) Хүний эрх хамгаалагчдад чиглэсэн эсхүл тэднийг дуугүй болгохын тулд сошиал медиа, мессежний платформыг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэхийн тулд олон улсын хүний эрхийн эрх зүйд нийцүүлэн МХХТ-ийн компаниудыг зохицуулах. Үүнд: МХХТ-ийн компаниудаас дарамт, аюул заналхийллийн талаарх мэдээлэлд шуурхай хариу арга хэмжээ авах механизмыг хэрэгжүүлэхийг шаардах, хүний эрх хамгаалагчдын цахим аюулгүй байдал, хувийн халдашгүй байдлыг хангах арга хэрэгслийг боловсруулах явдал хамаарна.
- (к) Мэдээлэл олж авах эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, уг эрхээ хамгаалахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авна. Үүнд: Интернэтэд хууль бусаар хяналт тавихгүй байх, аккаунт, төхөөрөмж, SIM карт зэргийг бүртгүүлэхийг шаардахгүй байх, хуурамч мэдээ, цахим гэмт хэргийн талаар тодорхой бус, дур зоргын, хэт өргөн хүрээтэй хууль батлах, эсхүл хүний эрх хамгаалагчдын дуугүй болгох эсхүл хяналт (цензур) тавихын тулд технологийн платформыг урвуулан ашиглах троллын фермүүд, интернэтийг хамаарах нэгж, бусад байгууллагыг (бригад) байгуулах.

10 ДУГААР ЗҮЙЛ

НӨӨЦИЙН ХҮРТЭЭМЖ

Тайлбар: Тунхаглалын 13 дугаар зүйлд хүний эрх хамгаалагчид хүний эрхийг дэмжих, хамгаалах тодорхой зорилгоор нөөцийг олж авах, ашиглах эрхтэй гэж заасан байдаг. Гэвч бодит байдал дээр тэд Санхүүгийн үйл ажиллагааны албанаас гаргасан зөвлөмж, түүнчлэн банкны тодорхой дүрэм, практик зэрэг санхүүгийн болон захиргааны янз бүрийн хязгаарлалтад байнга өртдөг. Доорх заалт нь уг асуудлыг авч үзнэ.

Улс орнууд дотоодын болон олон улсын санхүүжилт зэрэг хүний эрх хамгаалагчдын санхүүгийн эх үүсвэрийн урсгалд саад учруулах ёсгүй.

Тухайлбал улс орнууд:

- (а) Хүний эрх хамгаалагчид хувь хүмүүс, холбоод, сангууд, иргэний нийгмийн бусад байгууллага, Засгийн газар, тусламжийн агентлаг, хувийн хэвшил, НҮБ, бусад нэгжүүдээс түүний дотор өндөр хязгаарлалт бүхий орчинд үндэсний болон гадаадын байгууллагуудаас санхүүжилт, бусад эх үүсвэр хайх, хүлээн авах, ашиглах боломжтой байх явдлыг хангана.

- (б) Гадаадын хөндлөнгийн оролцоотой тэмцэх, үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, авлигатай тэмцэх, мөнгө угаах, терроризмтой тэмцэх зэрэг нэрийдлээр хүний эрх хамгаалагчид болон тэдгээрийн бүртгэлтэй, бүртгэлгүй холбоодын санхүүжилт, бусад эх үүсвэр хайх, хүлээн авах, ашиглах чадамжид саад учруулах аливаа ялгаварлан гадуурхсан, үндэслэлгүй, дур зоргын хязгаарлалт, нөхцөл, тайлагнах шаардлага болон бусад захиргааны үйл явц, саад тотгор тогтоохгүй байх.
- (в) Хүний эрх хамгаалах эрхийг хэрэгжүүлж байгаа аливаа хүн, хуулийн этгээдийг санхүүжилтийн эх үүсвэрт үндэслэн түүний дотор гадаадаас санхүүжилт авдаг гэдгээр ялгаварлан гадуурхахгүй, хариу арга хэмжээ авахгүй.

Үүнээс гадна улс орнууд:

- (г) Хүний эрх хамгаалах эрхээ бүрэн эдэлж, хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхийн тулд дангаар болон олон улсын хамтын ажиллагаагаар санхүүгийн эх үүсвэр, бусад зэрэг эх үүсвэрээр хангах юм.
- (д) Хүний эрхийн хамгаалал, үйл ажиллагааны хандивт хууль тогтоомж, татварын хөнгөлөлт үзүүлэх замаар хүний эрх хамгаалагчдыг дэмжих хувийн хэвшлийн буяны үйлс, санаачилгыг хөхиүлэн дэмжиж, нөхцөлийг бүрдүүлэх юм.

11 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын үеийн эрх ба хамгаалалт

Тайлбар: Энэхүү Тунхаглал нь мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын нөхцөлд улс орнуудын хүлээх үүргийн талаар тусгаагүй. Хүний эрх хамгаалагчид нь мөргөлдөөнийг зохицуулах, шийдвэрлэх, энх тайвныг тогтооход, үлэмж бөгөөд чухал үүрэг гүйцэтгэдэг тул доорх заалтуудын зорилго нь ийм нөхцөл байдлын үед тэднийг нэмэлт хамгаалалтаар хангах, онцгой нөхцөл байдлын улмаас тэдгээрийн эрх нь үндэслэлгүй бөгөөд шаардлагагүй байдлаар зөрчигдөж хохирогч болохгүй байх явдлыг хангах зорилготой юм.

Мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын нөхцөл байдал, түүний дотор эзлэн түрэмгийлэл, улс төрийн томоохон эмх замбараагүй байдал, байгалийн гамшиг, нийгмийн эрүүл мэндийн онц байдлын үед хүний эрх хамгаалах эрх, уг эрхийг эдэлж буй хүмүүсийг улс орнууд үргэлжлүүлэн хамгаалж, дэмжинэ.

Тухайлбал мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын нөхцөлд улс орнууд:

- (а) Мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, түүнийг зохицуулах, шийдвэрлэх, энх тайвныг тогтоох, түүний дотор албадан нүүлгэн шилжүүлэлтийн үед хүмүүнлэгийн тусламж үзүүлэхэд хүний эрх хамгаалагчдын үүргийг хүлээн зөвшөөрнө.

- (б) Хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагааг зайлшгүй шаардлагатай үйлчилгээ болохыг хүлээн зөвшөөрч, хүний эрхийн нөхцөл байдалд мониторинг хийх, тайлагнах зэргээр ажил, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг хангаж, хүний эрхийг бүрэн интеграцичлах, хүндэтгэхийн тулд мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын нөхцөлд хариу арга хэмжээ авах стратегийг төлөвлөх, хэрэгжүүлэхэд тэднийг оролцуулна.
- (в) Хүний эрх хамгаалагчдын эсрэг үйл ажиллагаа болгон тэдний тайван жагсаалыг гутаан доромжлох, нэр төрийг гутаах кампанит ажил, үзэн ядалтын үг хэллэгээс татгалзах, төрийн болон төрийн бус оролцогчид (түүний дотор бизнесийн байгууллагууд)-ын үйлдсэн аливаа үйлдлийг яаралтай шийдвэрлэх арга хэмжээ авна.
- (г) Зөрчилдөөн, хямралын нөхцөл байдалд хууль сахиулах, төрийн албан тушаалтнуудаас хэрэгжүүлдэг хариу арга хэмжээ нь хууль ёсны (түүний дотор үндсэн хуульд нийцсэн), зайлшгүй бөгөөд тохирсон байх, хариуцлагатай байх, хүний амь насанд аюул учруулахгүй байх, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмуудад нийцсэн, цаг хугацааны хувьд хязгаарлагдмал, олон улсын хүний эрхийн эрх зүйд нийцэж байгаа эсэхийг тогтмол хянах явдлыг хангана.
- (д) Олон улсын хүний эрхийн болон хүмүүнлэгийн эрх зүйн дагуу интернэтийг хаах, бусад сүлжээг хязгаарлах, түүний дотор харилцаа холбооны дэд бүтцэд биетээр болон цахимаар халдахаас татгалзана.
- (е) Мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын үед үзүүлэх үндэсний болон олон улсын хариу арга хэмжээ нь хүний эрх хамгаалах эрх, уг эрхийг эдэлж буй хүмүүсийг онилох, эсхүл тэдгээрт зүй бусаар хөндлөнгөөс нөлөөлөхөд хүргэхгүй байх явдлыг хангана.
- (ё) Мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын үед авах арга хэмжээ нь хүний эрхийн хүчирхийлэл үйлдсэн хууль сахиулах байгууллагад халдашгүй эрх олгохгүй байх явдлыг хангана.
- (ж) Мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын нөхцөл байдлыг шийдвэрлэхдээ онц байдлын хариу арга хэмжээ, эсхүл үндэсний аюулгүй байдлаар халхавчлан хүний эрх хамгаалагчдыг онилох, дарамтлах, цагдан хорих зорилгоор онц байдлын эрх мэдлийг урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлнэ.
- (з) Жагсаал, цуглааны үед цагдаагийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх аюулгүй байдлын хүчний албан хаагчдыг хүний эрхийн сургалтад хамруулах ялангуяа жагсаал, цуглааныг дэмжих, хурцадмал байдлыг даамжруулахгүй байх арга техникийг эзэмшүүлэх, тэднийг энгийн удирдлага, хяналтад байлгах, үүрэг, дүрэм журмыг нь ойлгомжтой тодорхойлох, хариуцлага хүлээх явдлыг хангана.
- (и) Хүний эрх хамгаалах эрх эдэлж буй хүмүүсийн эсрэг хариу арга хэмжээ болгон хэдийд ч хэт их хүч хэрэглэхгүй байх явдлыг хангана.
- (й) Мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын нөхцөл байдалд хүний эрх хамгаалагч болохынх нь хувьд болон үйл ажиллагаатай холбоотойгоор хэнийг ч хүмүүнлэгийн тусламжаас хязгаарлахгүй байх явдлыг хангана.

- (к) Онц байдлын санхүүжилт, хууль зүйн туслалцаа, эрүүл мэндийн үйлчилгээ, хүмүүнлэгийн туслалцаа зэрэг эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдад зориулсан дэмжлэгийн механизмыг бий болгоно.
- (л) Дрон, тандалтын технологи зэрэг дайны технологийг хүний эрх хамгаалагчид, тэдгээрийн бүлгүүдийг онилоход ашиглахгүй байх явдлыг хангана.
- (м) Сошиал медиаг хүний эрх хамгаалагчид тэдгээрийн бүлгүүдийг онилоход ашиглахгүй байх, түүнчлэн олон нийтийн үл итгэх байдлыг өдөөж, хүний эрхийг зөрчихөд хүргэж болзошгүй тул худал мэдээлэл, суртал ухуулга, үзэн ядсан үг хэллэгийг хүний эрх хамгаалагчийн эсрэг ашиглахгүй байх явдлыг хангана.
- (н) Хүмүүнлэгийн бүс, энх тайвны бүлэг байгуулах зэргээр өөрсдийн эрх ашгийг хамгаалах, нутаг дэвсгэрээ хүчирхийлэл, мөргөлдөөнөөс хамгаалах арга хэмжээ авсан бүлгийн эсрэг дайсагнасан үйлдэл хийхгүй.
- (о) Мөргөлдөөн, мөргөлдөөний дараах болон хямралын үед улс хоорондын хилийн дотор болон гадна албадан нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн хүмүүсийг ял шийтгэл, мөрдөн мөшгөлтөд өртөхгүйгээр, хүмүүнлэгийн тусламж, зайлшгүй шаардлагатай үйлчилгээнд хамрагдах боломжоо алдахгүйгээр эрхээ хамгаалах, тэднийг хүний эрх хамгаалагч болохыг хүлээн зөвшөөрөх явдлыг хангана.

III БҮЛЭГ. ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАГЧДАД ЧИГЛЭСЭН ЭРХ БОЛОН ХАМГААЛАЛТЫН ҮР НӨЛӨӨ

Тайлбар: Тунхаглал нь заавал биелүүлэх хүчинтэй баримт бичиг биш боловч уг баримт бичигт хүний эрх хамгаалагчдыг хамгаалах улс орнуудын олон улсын эрх зүйгээр хүлээсэн үүргийг тусгаж, нарийвчлан боловсруулсан. Гэвч зарим улс орнууд амлалтаа биелүүлээгүй байгаагийн зэрэгцээ Тунхаглалын зарчмуудын хэрэгжилтэд мониторинг хийх, тэдгээрт нийцүүлэх хүчин чармайлтад идэвхтэй саад учруулж байгаа нь Тунхаглалын бүрэн хэрэгжилт бэрхшээлтэй хэвээр байна. Энэ хэсэгт улс орнууд Тунхаглалыг үр дүнтэй хэрэгжүүлэх нэн чухал хэрэгцээ болон тунхаглалын 2, 3 дугаар зүйлд заасан зарчмын дагуу Тунхаглалд тусгагдсан эрх болон хамгаалалтыг хэрэгжүүлэх, хэрэгжилтийн үйл явцад мониторинг хийх, тайлагнах асуудлыг авч үзнэ.

12 ДУГААР ЗҮЙЛ

Тунхаглал болон Тунхаглал+25-ын хэрэгжилт

Улс орнууд Тунхаглал болон Тунхаглал+25-ыг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль тогтоох, захиргааны болон бусад алхмуудыг өөрийн хамаарах эрх зүй болон тус тусын харьяалах нутаг дэвсгэрт, ялангуяа Тунхаглал болон Тунхаглал+25-д заасны дагуу хүний эрх хамгаалагчдад олгосон эрх, хамгаалалтыг дотоодын хууль тогтоомжид тусгагдсан байх, орон нутгийн удирдлага, шүүхийн байгууллагууд хэрэгжүүлэх явдлыг хангана.

Тухайлбал улс орнууд:

- (а) Өөрийн харьяалах болон хяналтад байгаа нутаг дэвсгэртээ Тунхаглал болон Тунхаглал+25-ыг тэргүүлэх ач холбогдол өгч үр дүнтэй түгээх, хөхиүлэн дэмжиж, хэрэгжүүлнэ.
- (б) Тунхаглал болон Тунхаглал+25-д заасан эрх, эрх чөлөөг үр дүнтэй хэрэгжүүлэх явдлыг хангахын тулд хууль тогтоох, захиргааны болон бусад алхмуудыг батлах үйл явцад хүний эрх хамгаалагчид, иргэний нийгмийн бүлгүүд, хэвлэл мэдээлэл, төрийн бус бусад оролцогчид (үүнд: бизнесийн байгууллагуудыг оролцуулаад), хувь хүмүүс (үндэстний цөөнх, уугуул хүмүүс болон шашны удирдагчид)-тэй идэвхтэй бөгөөд үр дүнтэй зөвлөлдөх явдлыг хангана.
- (в) Хүний эрх хамгаалах эрхтэй холбоотой бүс нутгийн болон олон улсын хүний эрхийн байгууллага, механизмууд уг эрхийг эдэлж байгаа хүмүүсийг бүрэн дүүрэн дэмжих, хамтран ажиллах, эдгээр байгууллага, механизмаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг зохих ёсоор, шударгаар анхаарч үзнэ.
- (г) Тунхаглал болон Тунхаглал+25-д заасан эрхийг зөвхөн хууль тогтоомж, бодлогод хүлээн зөвшөөрөөд зогсохгүй, практикт хүндэтгэх, хамгаалах, мөрдүүлэхийн тулд шаардлагатай бүх арга хэмжээг авна.

13 ДУГААР ЗҮЙЛ

Мониторинг ба Тайлагналт

Улс орнууд Тунхаглал болон Тунхаглал+25, тэдгээрт тусгагдсан эрх, хамгаалалтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тогтмол мониторинг хийх, тайлагнах явдлыг хангана.

Тухайлбал улс орнууд:

- (а) Тунхаглал болон Тунхаглал+25-ын хэрэгжилтийг үнэлэх мониторингийн болон тайлагнах цогц тогтолцоо, шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулж мөрдүүлнэ. Энэ үйл явц нь иргэний нийгмийн оролцогчид, хүний эрх хамгаалагчдын идэвхтэй оролцоог хангахуйц тогтмол бөгөөд тэднийг бүрэн хамруулсан байна.
- (б) Хүний эрх хамгаалах эрхийг эдэлж буй хүмүүсийн эсрэг аюул заналхийлэл, халдлага болон ноцтой үр дагавар бүхий бусад хэлбэрүүдийн талаарх мониторинг хийх, тайлагнах цогц тогтолцоог бий болгох, хэвээр хадгалах. Энэхүү систем нь хүний эрх хамгаалагчдын эсрэг үйлдэгдсэн тохиолдлын талаар нарийвчилсан, бүрэлдэхүүн хэсгээр нь задалсан статистик, тэдгээрийн мөрдөн шалгасан болон ял шийтгэлийн түвшний талаарх холбогдох мэдээллийг багтаасан байх юм.
- (в) Хүний эрх хамгаалагчдад хамааралтай үндэсний, бүс нутгийн, олон улсын хүний эрхийн байгууллагууд, механизмуудаас тодорхойлсон сорилт бэрхшээлүүдийг шийдвэрлэх, зөвлөмжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах зэргээр арга хэмжээ авах юм.

14 ДҮГЭЭР ЗҮЙЛ

Хүний эрх хамгаалагчдад дипломат дэмжлэг үзүүлэх

Тайлбар: Дипломат нийгэмлэг нь үндэсний хэмжээнд хүний эрх хамгаалагчдыг дэмжих чухал эх сурвалж болдог. Үүнийг хүлээн зөвшөөрч, хэд хэдэн улс орон гадаадад суугаа өөрийн улсын Элчин сайдын яамд, төлөөлөгчийн газруудад хүний эрх хамгаалагчид ялангуяа эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдыг дэмжихийн тулд авч хэрэгжүүлэх алхам, арга хэмжээний талаар дипломат удирдамжийг боловсруулсан байна. Энэ хэсэгт улс орнууд Тунхаглал болон Тунхаглал+25-ыг харилцан хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх хэрэгцээ, түүнчлэн тухайн улсын нутаг дэвсгэрийн гадна эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдад чиглэсэн дипломат хамгаалалтыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх улс орнуудын хэрэгцээний талаар тусгасан.

Улс орнууд тухайн улсын нутаг дэвсгэрээс гадуур эрсдэлд орсон хүний эрх хамгаалагчдад илүү дипломат хамгаалалт, дэмжлэг үзүүлбэл зохино.

Тухайлбал улс орнууд:

- (а) Тунхаглал болон Тунхаглал+25-ыг бусад улс орнууд хэрэгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх стратеги боловсруулна.
- (б) Хүний эрх хамгаалах эрхийг хамгаалах, ялангуяа хүний эрх хамгаалагчдыг ялгаварлан гадуурхах, хүчирхийлэл, бусад хор уршиг учруулах эсхүл тэдний эрх, эрх чөлөө зөрчигдөх эрсдэлтэй улс орнуудад хүний эрх хамгаалах эрхийг эдэлж буй хүмүүсийг дэмжих, хамгаалахад хувь нэмэр оруулахын тулд дипломат сувгийг оролцуулан шаардлагатай бүх арга хэмжээг ашиглана.

15 ДУГААР ЗҮЙЛ

Нүүн шилжсэн, дүрвэсэн, эх орноосоо хөөгдсөн хүний эрх хамгаалагчдыг дэмжих

Тайлбар: Энэхүү “Тунхаглал+25”-ын төслийг боловсруулах явцад зөвлөлдсөн хүний эрх хамгаалагчид хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажил, үйл ажиллагаа явуулсны үр дүнд олон тооны хүндрэл бэрхшээлтэй тулгардаг тухай тэмдэглэсэн. Тухайлбал шилжилт хөдөлгөөний үед эсхүл эх орноосоо хөөгдсөн үед нь улаан хуудас ногдуулах, зорчихыг хориглох, эх орноос нь хөөх, хүний эрх хамгаалагчийн ажил, үйл ажиллагаа явуулахад бэрхшээл тулгарах зэрэг хамаарна.

Эдгээр саад бэрхшээл нь зөвхөн хүний эрх хамгаалагчдад өөрсдөд нь төдийгүй тэдний гэр бүл, хамт олонд нь нөлөөлж, улмаар салж, хагацахад хүрдэг. Энэхүү заалтад хүний эрх хамгаалагчдын аюулгүй зорчих, дамжин өнгөрөх эрхийг ялгаварлан гадуурхахгүйгээр баталгаатай болгох арга хэмжээг хэрэгжүүлэх, ингэснээр тэд нүүлгэн шилжүүлэлт, нутаг буцаагдахаас айх айдасгүйгээр хүний эрх хамгаалагч биш хүмүүстэй адил чөлөөтэй зорчих, дүрвэх, орогнол хүсэх баталгааг хангах арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээг тусгаасан.

Улс орнууд зорчих эрх чөлөөг хөнгөвчилж эрхийг хүндэтгэх, нүүн шилжиж байгаа, нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн, дүрвэсэн, эх орноосоо хөөгдсөн хүний эрх хамгаалагчдын аюулгүй байдлыг хангах, хүний эрх хамгаалах үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадварыг нь хангахад шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Тухайлбал улс орнууд:

- (а) Дүрвэгсдийн эрх зүйн байдлын тухай конвенц, олон улсын эрх зүйн бусад баримт бичиг, олон улсын заншлын хэм хэмжээнд заасны дагуу нүүн шилжиж байгаа, дүрвэсэн, эх орноосоо хөөгдсөн хүний эрх хамгаалагчдыг ажил, үйл ажиллагаатай нь холбоотойгоор дур зоргоор баривчлах, цагдан хорихоос хамгаалах, тэднийг мөрдөн мөшгөхийн тулд нутаг буцаахыг хориглосон заалтуудын үр ашгийг хүртэх явдлыг хангах.
- (б) Виз нь хүний эрх хамгаалагчдын үйл ажиллагаа явуулж байгаа нутаг дэвсгэрт тулгарсан эсхүл урьдчилан харах боломжтой эрсдэлтэй нөхцөл байдалд хүний эрх хамгаалагчдыг хамгаалах хэрэгсэл болохыг хүлээн зөвшөөрөх, хүний эрх хамгаалагчид, тэдний гэр бүлийн үндсэн эрх, хүний эрх хамгаалах ажил, үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжоор хангах

зорилгоор аяллын баримт бичиг, яаралтай виз, оршин суух зөвшөөрлийг хөнгөвчлөх, ялгаварлан гадуурхахгүй, түргэн шуурхай олгох явдлыг хангана.

- (в) Хүний эрхийн үйл ажиллагаатайгаа холбоотойгоор ялангуяа мөргөлдөөн, улс төрийн хямралын улмаас мөрдөн мөшгөлтөөс дүрвэж буй эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдыг аюулгүй дамжин өнгөрөх явдлыг хангана. Улс орнууд эдгээр хүний эрх хамгаалагчдын статусыг шударгаар, ил тод, нууцлалтай, цаг тухайд нь олгож, орогнол хүсэх эрхийг хангах бөгөөд олон улсын байгууллага, бусад улстай хамтран хүний эрх хамгаалагчдыг дахин суурьших боломжоор хангах, дахин суурьших үйл явцыг шуурхай байлгах явдлыг хангана.
- (г) Хүний эрх хамгаалагчдын цагаачлалын статус, тэр дундаа эх орноосоо хөөгдсөн эсэхээс үл хамааран тэдэнд хүний эрхийн ажил, үйл ажиллагаагаа дангаараа эсхүл бусадтай хамтарч хэрэгжүүлэх боломж олгох тухайлбал хүний эрх хамгаалагчид хүний эрх хамгаалах эрхээ хэрэгжүүлэх, мэдээлэл олж авах, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, хуран цуглах эрх чөлөө, зайлшгүй шаардлагатай үйлчилгээг авах, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөрлөх эрхээ ялгаварлан гадуурхахгүйгээр эдлэх боломжтой байна.
- (д) Нүүн шилжиж байгаа, албадан нүүлгэн шилжүүлэлтэд өртсөн, эх орноосоо хөөгдсөн хүний эрх хамгаалагчид, захиргаа, хууль эрх зүй, санхүүгийн бэрхшээлгүйгээр гэр бүлтэйгээ нэгдэх эрхээ эдлэх, гэр бүлтэйгээ нэгдсэний үр ашгийг нэн даруй хүртэх явдлыг хангана.

Улсын нутаг дэвсгэрийн гадна болон гадагш чиглэсэн зөрчилд хариу арга хэмжээ авах нь

Тайлбар: Хүний эрх хамгаалагчдад тулгарч буй сорилтууд нь дэлхий нийтийн шинж чанартай байгаа нь улс орнуудаас дотоодын аюул заналхийллээр зогсохгүй нутаг дэвсгэрээсээ гадуурх эрсдэл, зөрчлийн эсрэг хамгаалах арга хэмжээ авахыг шаардаж байна. Энэхүү заалт нь эдгээр зөрчлүүд хаанаас эхлэлтэй, хаана үйлдэгдэж байгаагаас үл хамааран хүний эрх хамгаалагчдын эсрэг ноцтой зөрчилд хариуцлага хүлээлгэхийг дэмжих талаарх улс орнуудын үүргийг онцолж байна.

Улс орнууд тус тусын болон хяналтдаа байдаг нутаг дэвсгэрийн дотор, эсхүл тухайн улсын харьяалах нутаг дэвсгэрийн гадна бий болсон, эсхүл үйлдэгдсэн аюул заналхийлэл, эрсдэл, халдлага, зөрчлөөс хүний эрх хамгаалагчдыг хамгаалан дэмжих бөгөөд тэд хаана байгаагаас үл хамааран хүний эрх хамгаалагчдын эрхийг бүх нийтээр хүндэтгэх, дагаж мөрдөх явдлыг хөхиүлэн дэмжинэ.

Тухайлбал улс орнууд:

- (а) Тус тусын нутаг дэвсгэр болон хяналтдаа байдаг нутаг дэвсгэрт хүний эрх хамгаалагчдын амь насыг хороох, хулгайлах, хууль бусаар нүүлгэх, консулын үйлчилгээг урвуулан ашиглах, зүй бус нэр хоч зүүлгэх, интерполыг урвуулан ашиглах, хүний эрх хамгаалагчдын гэр бүлийг онилох, хамтад нь шийтгэх, цахим халдлагууд болон аливаа бусад хэлбэрээр улс дамнасан дарамт шахалтаас хамгаалах дотоодын хууль тогтоомжийг баталж, мөрдүүлнэ.
- (б) Хүний эрх хамгаалагчдын эсрэг үйлдсэн олон улсын харгис хэрцгий гэмт хэргүүдэд хариуцлага хүлээлгэхийг дэмжихийн тулд тийм гэмт хэрэг үйлдэгдсэн тухай бүр түгээмэл харьяалалд хамааруулна.¹

¹ Тайлбар: Түгээмэл харьяалал гэдэг нь “Олон улсын хамтын нийгэмлэгт заналхийлэх” гэсэн ойлголтод үндэслэн тухайн гэмт хэрэг хаана үйлдэгдсэн, гэмт этгээд, хохирогчийн харьяаллаас үл хамаарч үйлдсэн гэмт хэрэгт хувь хүнийг яллах эрх зүйн зарчим юм.

Төрийн бус оролцогчдын талаар төрийн хүлээх үүрэг хариуцлага

Тайлбар: Тунхаглал нь зөвхөн улс орнууд төдийгүй бүх хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллагуудад, үүнд хүний эрх хамгаалах эрхийг хүндэтгэх үүрэг хүлээдэг төрийн бус олон оролцогчид, тэр дундаа зэвсэгт төрийн бус оролцогчидод хамаарна (Удиртгал, 11, 12.3, 19 дүгээр зүйл). Төрийн бус оролцогчид нь тухайн улсын нутаг дэвсгэрт оршин суудаг учир Тунхаглал болон Тунхаглал+25-ыг дагаж мөрдөх, хүний эрх хамгаалах эрхийг хамгаалахад хувь нэмрээ оруулах явдлыг хангах нь улс орнуудын хувьд зайлшгүй юм.

Улс орнууд төрийн бус оролцогчид (үүнд: бизнесийн байгууллагуудыг оролцуулан) хүний эрх хамгаалагчдыг хүндэтгэж, тэдний эрх, үйл ажиллагааг шууд болон шууд бусаар зөрчихгүй, хязгаарлахгүй байх явдлыг хангасан хууль, бодлогыг батлах, мөрдүүлэх шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Тухайлбал улс орнууд хүний эрх хамгаалагчидтай зөвлөлдсөний үндсэн дээр төрийн бус оролцогчид (үүнд: бизнесийн байгууллагуудыг оролцуулан):

- (а) Хүний эрх хамгаалах эрхийг хүндэтгэх, уг эрхийг эдэлж буй хүмүүс, тэдний бүлэгт халдаж, дарамтлахаас татгалзана.
- (б) Тэдний үйл ажиллагаа нь хүний эрх хамгаалах эрх, уг эрхийг эдэлж буй хүмүүст үзүүлж болох аливаа сөрөг нөлөөллийг тогтоох, урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээхийн тулд хүний эрхийн хэрэгжилтийн шалгалтыг явуулж, эдгээр арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлнэ.
- (в) Хүний эрх хамгаалагчдад учирч буй эрсдэлийг илрүүлсний эцэст үйл ажиллагааны зохистой чиглэлийг тодорхойлохын тулд холбогдох орон нутгийн, үндэсний болон олон улсын иргэний нийгмийн байгууллагуудтай зөвлөлдөнө.
- (д) Хүний эрх хамгаалагчдын эсрэг халдлага, хүчирхийлэлд холбогдсон байгууллагуудтай бизнесийн, сургалт-шинжлэх ухааны зэрэг аливаа харилцаанаас тохиромжтой байдлаар татгалзах.
- (д) Хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг дэмжих хүрээнд тэдэнтэй зөвшилцөн, санал бодлыг нь харгалзан үзэж, шаардлагатай нөөц, техникийн дэмжлэг үзүүлэх, тэдний дуу хоолойг олон нийтийн хүртээл болгох платформуудыг бүрдүүлэх замаар хамтран ажиллах.

Цаашилбал төрийн бус зэвсэгт этгээдүүдийн хувьд улс орнууд хүний эрх хамгаалах эрх, уг эрхийг эдэлж байгаа хүмүүсийн эрхийг олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйд нийцүүлэн хүндэтгэхийн тулд шаардлагатай бөгөөд боломжтой бүх арга хэмжээг авч, зөрчил, хүчирхийлэл үйлдэгдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэнэ.

Бизнесийн байгууллагуудын үүрэг, хариуцлага

Тайлбар: Тунхаглал нь зөвхөн улс орнуудад төдийгүй бүх хувь хүн, нийгмийн бүлэг, байгууллагуудад хамаарах хэдий ч (Удиртгал ба 11, 12.3, 19 дүгээр зүйл) хүний эрх хамгаалагчдын ажил, үйл ажиллагаанд саад учруулахгүй байх хувийн хэвшлийн хариуцлагыг зохих ёсоор тодорхойлоогүй юм. Хүний эрх хамгаалагчдын эсрэг дайралтууд гарсаар байгаа нь дэлхий нийтээр бизнесийн үйл ажиллагаатай холбоотой хор уршиг санаа зовоож байгаа бөгөөд хэлэлцүүлгийн тайлангуудад онцлон дурдсанчлан компаниудын үйл ажиллагаа, ханган нийлүүлэлтийн сүлжээ, бизнесийн харилцааны хүний эрх хамгаалагчдад үзүүлж буй сөрөг нөлөөллийн талаарх хяналт шалгалт, арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Бизнестэй холбоотой хор уршгийн талаар санаа зовниж буй хүний эрх хамгаалагчдын эсрэг халдлага бүс нутаг бүрд, бараг бизнесийн бүх салбарт гардаг. Эдгээр халдлагын ихэнх нь уур амьсгал, байгаль орчин, газрын эрхийг хамгаалах үйл ажиллагаа хэрэгжүүлдэг хүмүүсийн эсрэг байдаг бөгөөд уугуул хамгаалагчид үлэмж ихээр өртөж байна.

Энэхүү заалтад хамгаалагчийн эрхийг хүндэтгэх бизнесийн оролцогчдын үүргийг тодорхойлсон.

Хүний эрх хамгаалагчидтай зөвшилцсөний үндсэн дээр санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагч зэрэг бизнесийн байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаа, үйлдэл, эс үйлдэхүй нь хүний эрх хамгаалах эрх, уг эрхийг эдэлж буй хүмүүсийн эрхийг хязгаарлахгүй, зөрчихгүй байх явдлыг хангах, өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой болон бизнесийн харилцааны үр дүнд хүний эрх хамгаалагчид учирч болох сөрөг нөлөөллийг тодорхойлох, арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээнэ.

Тухайлбал хүний эрх хамгаалагчидтай аюулгүй, утга учиртай зөвлөлдөх үед бизнесийн байгууллагууд дараах үүргийг хүлээнэ:

- (а) Хүний эрх хамгаалагчдыг хүндэтгэх, хамгаалах, зөвлөлдөх, хөхиүлэн дэмжих, хүний эрх хамгаалагчдад учирсан сөрөг нөлөөллийг арилгах талаарх компанийн хэмжээний бодлогын амлалт, журмыг батлах, хэрэгжүүлэх, үнэлэх юм. Түүнчлэн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой, эсхүл бизнесийн харилцааны үр дүнд хүний эрх хамгаалагчдад бий болсон аливаа төрлийн аюул заналхийлэл, халдлага, айлган сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх, хувь нэмэр оруулахыг үл тэвчинэ.
- (б) Хүний эрх хамгаалагчид, тэдгээрийн бүлэгт учирч буй аюул заналхийлэл, эрсдэл, зөрчлийг авч үзсэн хүний эрх, байгаль орчны хэрэгжилтийн шалгалтыг хийх, хүний эрх, ба үндэстэн дамнасан компани, бизнесийн байгууллагын асуудлаар НҮБ-ын Ажлын бүлгээс боловсруулсан Бизнес ба хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмуудын жендэрийн удирдамжийн дагуу жендэрийн эрсдэл, нөлөөллийг тогтоож, шийдвэрлэнэ.

- (в) Хэрэгжилтийн шалгалтын журам нь чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах эрхийг хүндэтгэх явдлыг хангах, ингэхдээ чөлөөт, урьдчилсан, мэдээлэлтэйгээр зөвшөөрөл авах үйл явцыг тодорхойлох уугуул хүмүүсийн эрхийг Засгийн газрын аливаа эсэргүүцлээс үл хамааран тийм зөвшөөрөл өгөхөөс татгалзах эрхийг нь хүндэтгэх явдлыг хангана.
- г) Хүний эрх хамгаалах эрхийг зөрчих, уг эрхийг эдэлж байгаа хүмүүс, тэдгээрийн бүлэгт хор уршиг учруулж болзошгүй аливаа төсөл, санаачилгыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэхээс татгалзана.
- (д) Хүний эрх хамгаалагчид болон бизнесийн үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандаж болзошгүй бусад оролцогчдын эсрэг Олон нийтийн оролцооны эсрэг стратегийн нэхэмжлэл (ОНОЭСН), шүүхийн хүчирхийллийн бусад тактик ашиглахгүй.
- (е) Хүний эрх хамгаалах эрхийг хэрэгжүүлж буй хүмүүст аюул заналхийлэл, сөрөг нөлөөлөл үзүүлэхэд компани оролцсон гэх аливаа мэдэгдлийн талаар хариу арга хэмжээ авна. Үүнд: ил тод байдал, хариуцлага хүлээлгэх явдлыг хангах, хүний эрх хамгаалагчдад үзүүлсэн сөрөг нөлөөллийн талаарх мэдээллийн хариуд авсан арга хэмжээний талаар олон нийтэд мэдээлэх багтана.
- (ё) Боломжит ханган нийлүүлэгчидтэй гэрээ байгуулах, бусад хэлбэрээр бизнесийн харилцаанд оролцоходоо тэдгээрийн хүний эрхийн үүрэг амлалт, нөлөөлөл, тайланг үнэлнэ.
- (ж) НҮБ-ын Бизнес ба Хүний эрхийн чиглэлээр баримтлах зарчмууд, Хүний эрхийг хамгаалагчдыг хүндэтгэхийг баталгаажуулах талаарх НҮБ-ын Ажлын хэсгийн удирдамжийн дагуу бизнесийн үйл ажиллагаа, харилцааны сөрөг нөлөөлөлд өртсөн хүний эрх хамгаалагчдын зөрчигдсөн эрхийг үр дүнтэй сэргээх механизмын хүртээмжтэй байдлыг хангана.
- (з) Эрсдэлд байгаа хүний эрх хамгаалагчдыг дэмжихэд нөлөөлөл үзүүлэх зэргээр иргэний эрх чөлөө, хүний эрхийг хамгаалах таатай орчныг бүрдүүлэхэд идэвхтэй дэмжлэг үзүүлэх, түүнчлэн хүний эрхийг хамгаалагчдад эрүүгийн ял шийтгэл оногдуулж болзошгүй хууль, бодлого, үйл ажиллагаа зэргээр хүний эрх, иргэний эрх чөлөөг хязгаарласан бодлогыг лоббидохоос татгалзана.
- (и) Хүний эрх хамгаалах эрх, уг эрхийг хэрэгжүүлж буй хүмүүсийн эрхийг урьдчилан таамаглаж болох хязгаарлалт, зөрчиж болзошгүй технологийг хөгжүүлэх, ашиглахаас татгалзах, хүний эрх хамгаалагчдын ажил, үйл ажиллагаанд нөлөөлөхүйц технологийн хүртээмжийг хязгаарлана.

Олон улсын болон бүс нутгийн байгууллага, механизмын үүрэг, хариуцлага

Тайлбар: НҮБ, Дэлхийн Худалдааны Байгууллага болон бусад олон улсын санхүүгийн байгууллагууд зэрэг олон улсын болон бүс нутгийн байгууллагууд дэлхийн хэмжээнд асар их нөлөөтэй байдаг. Тухайлбал тэд олон улсын хэм хэмжээг зөрчсөн улс орнууд (түүнчлэн төрийн бус оролцогчид)-ад хориг тогтоох чадвартай бөгөөд энэ нь олон улсын хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйг үл тоомсорлох явдлыг зогсоодог. Нөлөө, нөөц, улс төрийн хүрээг хүний эрх хамгаалах эрхийг эргээр мөрдүүлэхэд ашиглах ёстой.

Энэхүү зүйлд Тунхаглал болон Тунхаглал+25-ыг хэрэгжүүлэхэд олон улсын болон бүс нутгийн эдгээр байгууллагуудын үүрэг, хариуцлагыг тодорхойлсон.

Олон улсын болон бүс нутгийн байгууллага, механизм, үйл явц, түүний дотор олон талт үйл явц нь хүний эрх хамгаалагчидтай зөвшилцсөний үндсэн дээр хууль тогтоомж, бодлогыг батлах, хэрэгжүүлэх, шаардлагатай бүх арга хэмжээг авах, хүний эрхийг хамгаалах эрх, ялангуяа олон улсын болон бүс нутгийн байгууллага, механизм, үйл явцад харилцах, хамтран ажиллах эрхийг хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлэх боломжийг олговол зохино. Үүнд:

- (а) Эдгээр байгууллага хүний эрх хамгаалагчидтай холбоотой механизмаас боловсруулсан аливаа хууль, бодлого, журам нь олон улсын хүний эрхийн стандартад нийцэж байх явдлыг хангана.
- (б) Хүний эрх хамгаалагчдыг олон улсын болон бүс нутгийн байгууллага, механизм, процесст аюулгүй, утга учиртай хандах, оролцох явдлыг хангана.
- (в) Хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөний талаарх мэдээллийг олж авах боломжийг олгон хүртээмжийг дэмжинэ.
- (г) Хүний эрх хамгаалах эрх, олон улсын болон бүс нутгийн байгууллага, механизм, процесст хандах, харилцах, хамтран ажиллах эрх эдлэх, тийнхүү эрхээ эдлэх оролдлоготой холбоотойгоор айлган сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх бүх үйлдлээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хариуцлага хүлээлгэх явдлыг дэмжинэ.
- (д) Айлган сүрдүүлэх, дарамт шахалт үзүүлэх үйлдэлд буруутай төрийн болон төрийн бус оролцогчдод хариуцлага хүлээлгэх, тийм зөрчлийг дахин гаргуулахгүй байх явдлыг дэмжинэ.

#ЭрхХамгаалах ЭРХ

ХҮНИЙ ЭРХ ХАМГААЛАХ ЭРХ ЭДГЭЭР ИРГЭНИЙ НИЙГМИЙН БАЙГУУЛЛАГУУД
ТУНХАГЛАЛ+25-ЫГ БОЛОВСРУУЛАХАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ
ЭВСЛИЙН БҮЛЭГТ ХАМААРНА.



ИЛҮҮ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ДАРААХ ЛИНКЭЭР АВНА УУ.

<https://ishr.ch/defenders-toolbox/resources/declaration-25/>